

**Хүүхдийн эмчийн /ажиллагсад/ мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын
жишиг сорил-2**

Сорилын зөв хариулт

1-C, 2-D, 3-B, 4-D, 5-D, 6-C, 7-B, 8-C, 9-A, 10-D, 11-B, 12-E, 13-E, 14-C, 15-E, 16-E, 17-E, 18-B, 19-C, 20-B, 21-A, 22-E, 23-B, 24-A, 25-A, 26-C, 27-E, 28-A, 29-B, 30-E, 31-C, 32-D, 33-E, 34-C, 35-C, 36-B, 37-E, 38-B, 39-C, 40-A, 41-A, 42-A, 43-E, 44-A, 45-E, 46-A, 47-A, 48-A, 49-B, 50-E, 51-D, 52-A, 53-A, 54-E, 55-C, 56-E, 57-A, 58-B, 59-C, 60-E, 61-A, 62-A, 63-C, 64-A, 65-A, 66-B, 67-C, 68-E, 69-C, 70-A, 71-A, 72-A, 73-B, 74-C, 75-C, 76-C, 77-E, 78-B, 79-C, 80-A, 81-E, 82-A, 83-D, 84-E, 85-C, 86-C, 87-C, 88-A, 89-A, 90-B, 91-C, 92-B, 93-E, 94-B, 95-B, 96-A, 97-C, 98-B, 99-A, 100-D, 101-D, 102-A, 103-B, 104-C, 105-C, 106-A, 107-C, 108-D, 109-E, 110-D, 111-B, 112-D, 113-C, 114-D, 115-B, 116-B, 117-B, 118-C, 119-B, 120-B, 121-A, 122-E, 123-B, 124-E, 125-A, 126-B, 127-C, 128-E, 129-C, 130-E, 131-E, 132-A, 133-E, 134-E, 135-E, 136-C, 137-C, 138-B, 139-B, 140-B, 141-E, 142-C, 143-E, 144-D, 145-E, 146-B, 147-E, 148-B, 149-C, 150-E, 151-D, 152-E, 153-C, 154-A, 155-A, 156-A, 157-C, 158-E, 159-E, 160-E, 161-A, 162-E, 163-B, 164-C, 165-E, 166-B, 167-A, 168-C, 169-A, 170-B, 171-C, 172-D, 173-A, 174-B, 175-A, 176-A, 177-E, 178-C, 179-A, 180-E, 181-E, 182-B, 183-E, 184-E, 185-C, 186-B, 187-C, 188-E, 189-D, 190-D, 191-C, 192-B, 193-B, 194-C, 195-C, 196-C, 197-B, 198-E, 199-A, 200-E, 201-A, 202-B, 203-E, 204-D, 205-B, 206-A, 207-E, 208-A, 209-A, 210-A, 211-E, 212-E, 213-A, 214-E, 215-B, 216-C, 217-A, 218-B, 219-E, 220-A, 221-E, 222-E, 223-E, 224-B, 225-A, 226-C, 227-B, 228-B, 229-E, 230-D, 231-C, 232-E, 233-C, 234-C, 235-B, 236-C, 237-D, 238-D, 239-C, 240-A, 241-A, 242-C, 243-E, 244-D, 245-B, 246-A, 247-C, 248-E, 249-E, 250-B, 251-B, 252-E, 253-C, 254-A, 255-C, 256-B, 257-B, 258-C, 259-B, 260-A, 261-D, 262-C, 263-D, 264-E, 265-B, 266-B, 267-C, 268-C, 269-E, 270-B, 271-A, 272-C, 273-C, 274-A, 275-B, 276-A, 277-B, 278-C, 279-A, 280-A, 281-A, 282-E, 283-A, 284-B, 285-D, 286-D, 287-A, 288-D, 289-C, 290-A, 291-E, 292-A, 293-A, 294-A, 295-E, 296-D, 297-A, 298-E, 299-D, 300-A, 301-B, 302-A, 303-D, 304-B, 305-C, 306-E, 307-D, 308-D, 309-C, 310-E, 311-E, 312-C, 313-C, 314-A, 315-B, 316-A, 317-C, 318-C, 319-E, 320-A, 321-E, 322-A, 323-C, 324-C, 325-E, 326-B, 327-A, 328-A, 329-A, 330-D, 331-D, 332-D, 333-C, 334-D, 335-B, 336-C, 337-A, 338-D, 339-E, 340-C, 341-C, 342-C, 343-A, 344-E, 345-E, 346-A, 347-C, 348-B, 349-E, 350-C, 351-D, 352-E, 353-A, 354-D, 355-C, 356-D, 357-C, 358-E, 359-D, 360-E, 361-D, 362-B, 363-A, 364-E, 365-B, 366-C, 367-D, 368-A, 369-E, 370-A, 371-D, 372-A, 373-E, 374-D, 375-B, 376-E, 377-E, 378-E, 379-C, 380-E, 381-E, 382-B, 383-C, 384-E, 385-A, 386-E, 387-A, 388-E, 389-B,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Аль үүсгэгч давамгайлж шээс дамжуулах замын халдварыг үүсгэдэг вэ?

- A. А. Хламид
- B. В. Вирүс

- C. C. E.Coli
- D. D. Стафилококк
- E. E. Энтерококк

/2./ Давсаг-шээлэйн сөрөг урсгалыг олон улсын ангиллаар хэдэн зэрэг болгох вэ?

- A. 2
- B. 1
- C. 3
- D. 5
- E. 4

/3./ Шээс дамжуулах замын халдвар ахлах насныханы дунд аль хүйсэнд илүү тохиолдох вэ?

- A. Эр
- B. Эм
- C. Хоёуланд нь
- D. Хүйснээс хамаарахгүй
- E. Эрэгтэйд бага тохиолдоно

/4./ Пиелонефритийг бөөр-шээсний замын халдвараас ялган оношилох хамгийн гол шинжийг сонгоно уу?

- A. Хэвлий, ууц нуруугаар өвдөх
- B. Лейкоцитури
- C. Бактериури
- D. Протеинури
- E. Лейкоцитоз нейтрофилын зүүний хазайлт

/5./ Шээс дамжуулах замын халдвар гэдэг нь

- A. Давсагнаас бөөр хүртэлх хаа нэгтээ байгаа халдварыг
- B. Аяганцар тэвшинцэрт байгаа халдварыг
- C. Шээсний сувагт байгаа халдварыг
- D. Шээсний сувгаас бөөр хүртэлх хаа нэгтээ байгаа халдварыг
- E. Түүдгэнцрийн үрэвсэл

/6./ 5 настай охин бүх биеэр хавантай, бөөлжинө, цустай шээнэ, шээсний гарц багассан гэсэн зовуурьтай хэвтжээ. Шинжилгээнд макрогематури, протейнури, азотеми, гипопротейнеми, гипоальбуминеми, гиперлипидеми гарчээ. Энэ өвчин 1 жил үргэлжилж байгаа. Ямар эмгэг байж болох вэ?

- A. Липойдний нефроз
- B. Архаг ГН-ийн гематурийн хэлбэр
- C. Архаг ГН-ийн холимог хэлбэр
- D. IgA нефропати
- E. Бержийн өвчин

/7./ Шээс дамжуулах замын халдвар нярай, бага насныханы дунд аль хүйсэнд илүү тохиолдох вэ?

- A. Эм
- B. Эр
- C. Хоёуланд нь
- D. Хүйснээс хамаарахгүй
- E. Эрэгтэйд бага тохиолдоно

/8./ Хүүхдийн бөөрний тунгалгийн судас гэдэсний тунгалгийн судастай шууд холбоотой байдаг анатоми-физиологийн онцлогтой уялдан бөөрний ямар эмгэг үүсч болох вэ?

- A. Гломерулонефрит
- B. Хавагнах хамшинж
- C. Пиелонефрит
- D. Бөөрний чулуу
- E. Бөөрний амилоидоз

/9./ 5 настай охин бүх биеэр хавантай, бөөлжинө, шээсний гарц багассан гэсэн зовуурьтай хэвтжээ. Шинжилгээнд протейнури, гипопротейнеми, гипоальбуминеми, гиперлипидеми гарчээ. Ямар эмгэг байж болох вэ?

- A. Липойдний нефроз
- B. Архаг ГН-ийн гематурийн хэлбэр

- C. Архаг ГН-ийн холимог хэлбэр
- D. IgA нефропати
- E. Бержийн өвчин

/10./ 7 настай охин 23 хоногийн өмнө ханиад хүрч, 38oC хүртэл халуурч, гэдэс өвдсөн ба хөлөөр тод улаан тууралт ганц нэг гарч арилсан. 3 хоногийн өмнөөс шээсний өнгө өөрчлөгдөж кола шиг хүрэн болсон. Ямар өвчнийг сэжиглэж болох вэ?

- A. Цочмог гломерулонефрит
- B. Цочмог пиелонефрит
- C. Давсагны цочмог үрэвсэл
- D. Шенлейн-Хенохын нефрит
- E. Бержийн нефрит

/11./ Пиелонефритийн хамгийн зөв тодорхойлолтыг сонгоно уу?

- A. Бөөрний сувганцар, завсар эдээс илүүтэйгээр бөөрний түүдгэнцэр анхдагчаар гэмтэх халдвар харшлын эмгэг юм
- B. Өвөрмөц бус халдварын шалтгаантай бөөрний сувганцар завсар эд, цуглуулах системд байрлах цусны болон тунгалгийн судсыг хамарсан эмгэг
- C. Бөөр-шээсний замын халдвар
- D. Бөөрний аяганцар-тэвшинцрийг хамарсан үрэвсэл
- E. Өвөрмөц халдварын шалтгаантай бөөрний сувганцар завсар эд, цуглуулах системд байрлах цусны болон тунгалгийн судсыг хамарсан эмгэг

/12./ Бактериури гэдэг нь:

- A. Эхэн үеийн хөөстэй үнэртэй шээсийг
- B. Давсганд 4 цагаас доошгүй хугацаанд байсан дунд үеийн цэвэр шээс
- C. Лейкоцит 102 дээш байх
- D. Нян 103 дээш байх
- E. Давсганд 4 цагаас дээш хугацаанд байсан шээсэнд нян 105 дээш байх

/13./ Хүүхдийн шээлэйн онцлог нь :

- 1. Харьцангуй өргөн
- 2. 0.3 - 0.4 см зузаан ханатай
- 3. Нугалаа ихтэй
- 4. Булчингийн ширхэг сул хөгжсөн
- 5. Уян эд сул хөгжсөн

/14./ Цочмог ГН-ийн хэдэн хувьд макрогематури илрэх вэ?

- 1. 10
- 2. 30
- 3. 40
- 4. 50
- 5. 100

/15./ Глюкокортикоид эмчилгээний гаж нөлөө юу вэ?

- 1. Иценго-Кушингийн хамшинж
- 2. Артерийн даралт ихдэх
- 3. Остеопороз
- 4. Гипергликеми
- 5. Хоёрдогч халдвар үүсэх

/16./ Архаг ГН-ийн шалтгаанд аль нь орох вэ?

- 1. Бөөрөнд халтай эм
- 2. Үрэвслийн эсрэг стероид бус эмийг удаан хэрэглэх
- 3. Халдварын архаг голомт
- 4. Вирүсийн халдвар
- 5. Ахуйн таагүй байдал

/17./ Дараах эмгэгтөрөгчдийн аль нь охидод илүүтэй бөөр-шээсний замын халдварын шалтгаан болох вэ?

- 1. Klebsiella spp
- 2. Proteus spp
- 3. Escherichia coli
- 4. Хламид

5. *Staphylococcus saprophyticus*
- /18./ Цитостатик эмчилгээний ГН-ийн үед үйлчлэх механизм
1. Нуклейн хүчилтэй холбогдоно
 2. ДНК-ийн синтезийг дарангуйлна
 3. Эсийн хуваагдлыг зогсооно
 4. Т-хелпер интерлейкин-2-ын идэвхийг дарангуйлна
 5. Түүдгэнцрийн ханын синтезийг идэвхжүүлнэ
- /19./ Пиелонефритийг аль өвчнүүдээс ялган оношилох вэ?
1. Тубулопати
 2. Бөөрний сүрьеэ
 3. Бөөрний амилоидоз
 4. Гломерулонефрит
 5. Бөөр-шээсний замын чулуу
- /20./ Цочмог ГН-ийн үед
1. Эргэлдэгч ба бөөрний түүдгэнцэрт бэхлэгдсэн антиглобулин илэрнэ
 2. Сийвэнгийн хавсарга СЗ буурна
 3. Сийвэнд фибриногений бүрдэл ихэснэ
 4. Бөөрний түүдгэнцэрт IgG СЗ-ын бөөгнөрөл илэрнэ
 5. Бөөрний түүдгэнцэрт хагас саран бөөгнөрөл харагдана
- /21./ Цочмог гломерулонефритийн үед хавагнаж байгаа шалтгаан
1. Цус, шээс ба эдийн эрдсийн бүрэлдэхүүн хямрах
 2. Хялгасан судасны эзлэхүүн өөрчлөгдөх
 3. Цусны уураг багассанаас сийвэнгийн онкотик даралт хямрах
 4. Түүдгэнцрийн шүүрэлтийн хурд нэмэгдсэнээс
 5. Сувганцрын эргэн шимэгдэлт буурснаас
- /22./ Түргэн даамжрах ГН-ийн эмчилгээний аргуудыг сонгоно уу.
1. Стероид эм
 2. Азатиоприн
 3. Циклофосфамид
 4. Гепарин
 5. Дээр дурьдагдсан эмүүдийг янз бүрийн хувилбараар хослуулах
- /23./ Түргэн даамжрах явцтай гломерулонефритийн үед
1. Протейнури
 2. Макрогематури
 3. Олигоури
 4. Артерийн даралт ихэснэ
 5. Пиури
- /24./ Шээс дамжуулах замын халдварт аль нь орох вэ?
1. Пиелонефрит
 2. Цистит
 3. Уретрит
 4. Гломерулонефрит
 5. Тубулопати
- /25./ Гломерулонефритын шалтгаан
1. Стрептококкийн шалтгаантай халдвараар өвдсөний дараа
 2. Халдвар-харшлын шалтгаан
 3. Дархлааны өвөрмөц бус хүчин зүйл
 4. *E. coli*, хөх идээний савханцар
 5. Кандида
- /26./ Бөөр-шээсний замын халдвартай хүүхдэд илэрч болох өөрчлөлтүүдийг сонгоно уу?
1. Лейкоцитоз, саармагсаг эс багасах, лимфоцитоз
 2. Пиури, шээсэнд нитрит эерэг байх
 3. Шээсэнд эмгэгтөрөгч 5000 илрэх
 4. Лейкоцитоз, саармагсаг эс ихсэх
 5. Аддисын сорилд лейкоцит 1 сая
- /27./ Цочмог ГН-ийн үед өвчтнийг хагас хэвтрийн дэглэмд шилжүүлэх заалт

1. Артерийн даралт хэвийн
 2. Хавангүй
 3. СОЭ хэвийн
 4. Шээсний ерөнхий шинжилгээнд уураг 1% хүртэл буурсан
 5. Улаан эсийн тоо цөөрсөн (30-40 х/т)
- /28./ Цочмог гломерулонефритын хэлбэрүүдийг нэрлэ.
1. Нефротик шинжтэй
 2. Нефритик шинжтэй
 3. Зөвхөн шээсний хамшинжтэй
 4. Гэр бүлийн бөөрний үрэвсэл
 5. Холимог
- /29./ Архаг ГН-ийн эмгэг бүтцийн ангилалд орох хэлбэрүүдийг сонгоно уу
1. Мембранозно-пролифератив
 2. Фокально-сегментар гломерулосклероз
 3. Мембраноз
 4. Бөөрний завсар эдэд лимфоцитын тоо ихэснэ
 5. Эдийн бага зэргийн өөрчлөлт
- /30./ Шээс цустах хэлбэрийн ГН-ийг ямар өвчнөөс ялган оношилох вэ?
1. Бөөрний сүрьеэ
 2. Бөөр чулуужих өвчин
 3. Бөөрний хавдар
 4. Давсагны үрэвсэл
 5. Чонон хөрвөс
- /31./ Архаг ГН нь
1. Хүнд явцтай
 2. Эмнэлзүйн хувьд дахидаг
 3. Бөөрний дутагдалд амархан ордог
 4. Бүтцийн эргэшгүй өөрчлөлтөнд ордог
 5. Зөвхөн анхдагч өвчний үед илэрнэ
- /32./ ГН-ийн ялган оношилгоонд юу ашигладаг вэ?
1. Хавагнах шинж
 2. Артерийн даралт ихсэх шинж
 3. Хэлбэрээ алдаагүй эритроцит бүхий гематури
 4. Хэлбэрээ алдсан эритроцит бүхий гематури
 5. Протейнури
- /33./ Архаг ГН-ийн урьдчилан сэргийлэлтэнд
1. ГН-ийн идэвхжлийг цаг тухайд нь оношилох, өвчний явцыг хянах
 2. Биед буй архаг голомтот үрэвслийг эмчилнэ
 3. Мэс ажилбараар эмчлэх шаардлагатай бол зөвхөн өвчний намжилтын үед хийнэ
 4. Хөдөлгөөн зохицуулалт хийнэ
 5. Эмчийн хяналтанд тогтмол ШЕШ, биохимийн шинжилгээ өгч үзүүлж байх
- /34./ Аль нь бөөр-шээсний замын өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл биш вэ?
1. Биеийн ерөнхий ба хэсэг газрын эсэргүүцэл сул
 2. Хүүхэд голдуу илүү тээлттэй байх
 3. Бөөрний эдийн хөгжил бүрэн гүйцээгүй
 4. Жирэмсэн үеийн ургийн хөдөлгөөний идэвх сул байх
 5. Шээсний урсгалын төрөлхийн ба олдмол саад
- /35./ Архаг ГН-ийн үед багажийн шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ?
1. АТС өргөснө
 2. ЭХО ойлт 2 бөөрөнд ижил ихэснэ
 3. Ходсоны шинж зэрэг
 4. Өвчний хожуу үед хоёр бөөр жижигрэнэ
 5. Ирмэг тэгш бус болно
- /36./ D-аминдэм ямар үүрэгтэй вэ?
1. Бөөрөнд кальци-фосфорын эргэн шимэгдэлтийг нэмэгдүүлнэ
 2. Булчингийн агшилтыг сайжруулна

3. Ясжилтыг нэмэгдүүлнэ
 4. Гэдсэнд кальцийн шимэгдэлтийг сайжруулна
 5. Яснаас кальци угаагдаж гарахад нөлөөлнө
- /37./ Глюкокортикостеройд нь ГН-ийн эмгэгжамын эмчилгээнд ямар үүрэгтэй вэ?
1. Дархан бүрдлийн үүсэлтийг удаашруулна
 2. Эсрэгбиеийн үүсэлтийг дарангуйлна
 3. Хемотаксис болох
 4. Үрэвслийн медиатр, лизосомын фермент ялгаралтыг багасгана
 5. Эсийн мембраныг тогтворжуулах үйлчлэлтэй
- /38./ Пиелонефритийн эмчилгээний зорилго нь:
1. Халдварын эсрэг
 2. Зовуурийг бууруулах
 3. Бөөр сорвижихоос сэргийлэх
 4. Дахилтаас сэргийлэх
 5. Хавангийн эсрэг
- /39./ Цочмог ГН-ийн үед эмнэлзүйд давамгайлан илрэх эмнэлзүйн хамшинжийг сонгоно уу
1. Нефроз хамшинж
 2. Нефрит хамшинж
 3. Холимог хамшинж
 4. АД ихсэх хамшинж
 5. Өвдөлтийн хамшинж
- /40./ Цочмог ГН-ийн хүндрэл
1. Бөөрний эклампси
 2. Бөөрний цочмог дутагдал
 3. Зүүн ховдлын цочмог дутагдал
 4. Бөөрний архаг дутагдал
 5. Гиповолемийн шок
- /41./ ГН-ийн үед үүсэх хавангийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлс
1. Шээсээр ялгарах уургийн хэмжээ
 2. Ууж байгаа шингэний хэмжээ
 3. Түүдгэнцрийн шүүрлийн хэмжээ
 4. Цусны кальци багасах
 5. Уургийн онкос даралт өөрчлөгдөхгүй байх
- /42./ Шээсний ерөнхий шинжилгээнд мөхлөгт бортгонцор, гиалин бортгонцор нь юуг илэрхийлэх вэ?
1. Түүдгэнцрийн эмгэгүүдийг илэрхийлнэ
 2. Шээсэнд уураг ялгарч буйг илэрхийлнэ
 3. Шээсэнд улаан эс гарч байгааг илэрхийлнэ
 4. Сувганцрын эмгэгийг илэрхийлнэ
 5. Шээсэнд нян байгааг илэрхийлнэ
- /43./ Архаг ГН-ийг ямар өвчнүүдээс ялган оношлох вэ?
1. Архаг пиелонефрит
 2. Шээс чулуужих өвчин
 3. Удамшлын нефрит
 4. Бөөрний судасны эмгэг
 5. Эмийн эмчилгээний хүндрэл
- /44./ 3 хүртэлх насны хүүхдэд шээс дамжуулах замын халдварын өвөрмөц шинж илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?
1. Шээсний ерөнхий шинжилгээ
 2. Шээсэнд нян ургуулах
 3. Антибиотик эмчилгээг шууд эхлэх
 4. Биохимийн шинжилгээ
 5. Цистографийн шинжилгээ
- /45./ 3 настай охин халуурсан, ойр ойрхон шээнэ, шээхэд өвдөнө гэсэн зовуурьтай эмчид ханджээ. Нэн шаардлагатай шинжилгээнүүдийг сонгоно уу.
1. ШЕШ

2. Шээсэнд нян ургуулах
 3. Хэвлийн ЭХО
 4. Цусны ерөнхий шинжилгээ
 5. Биохими
- /46./ Охидын шээсний сувгийн онцлог нь:
1. Шээсний суваг өргөн
 2. Маш богинохон
 3. Уян, холбогч эдийн хөгжил дутмаг
 4. Булчингийн ширхэг сайн хөгжсөн
 5. 3-6 см урт байдаг
- /47./ Дараах эмгэгүүдийн аль нь бөөр-шээсний замын халдварын үндсэн хэлбэрт орох вэ?
1. Цистит
 2. Шинж тэмдэггүй бактериури
 3. Пиелонефрит
 4. Тубулопати
 5. Интерстициальный нефрит
- /48./ Цочмог гломерулонефритийн үед эмнэлзүүд гарах шинжүүд.
1. Шээс цустах, бортгонцортох
 2. Шээсний гарц багасах
 3. Шээсний нягт хэвийн эсвэл ихсэх
 4. Шээсний нягт багасах
 5. Шээсний гарц ихсэх
- /49./ Суларсан амьсгал ямар эмгэгүүдийн үед сонсогдох вэ?
1. Уушгинд авчилз үүсэх
 2. Уушгины эд хатуурах
 3. Чээжний гялтан хөндийд хий, шингэн хуралдах
 4. Гялтан хальс зузаарах
 5. Төвөнхийн нарийсал
- /50./ Архаг гломерулонефритийн үед:
1. Дархлалын эмгэг урвалын дүнд түүдгэнцэр гэмтэнэ
 2. Нефронд гипертрофи, гиперфилтраци явагдана
 3. Хэвийн үйл ажиллагаатай нефроны тоо цөөрнө
 4. Түүдгэнцрийн дотоод даралт ихэснэ
 5. Түүдгэнцрийн шүүрүүлэх үйл ажиллагаа багасна
- /51./ Хурдан даамжрах ГН-ийн үед эдийн шинжилгээнд илрэх хамгийн онцлог шинжийг сонгоно уу
1. Мезанги эсийн олшрол
 2. Түүдгэнцрийн бага зэргийн өөрчлөлт
 3. Түүдгэнцэрт IgA-ийн хуримтлал үүсэх
 4. Түүдгэнцэрт "Хагас сар илрэх"
 5. Түүдгэнцрийн суурь хальс зузаарах
- /52./ Цочмог гломерулонефритийн үед хийх эмчилгээний зарчмыг сонгоно уу
1. Хоол, хөдөлгөөний дэглэм сахих
 2. Бактерийн эсрэг эмчилгээ
 3. Шинж тэмдгийн эмчилгээ
 4. Эмгэг жамын эмчилгээ
 5. Иммунодепрессант эмчилгээ
- /53./ Пульс эмчилгээнд тохирох тунг сонгоно уу?
1. Преднизолон 1000-1200 мг
 2. Гепарин 50000 ЕД
 3. Циклофосфамид 500-1000 мг
 4. Фуросемид 20-80 мг
 5. Курантил хоногт 225-400 мг
- /54./ Нефрогенный штаммд цус задлагч А-бүлгийн стерптококкийн ямар омгууд багтдаг вэ?
1. M4
 2. M12

3. M18
 4. M25
 5. M49
- /55./ Пиелонефритийг интерстециальный нефритээс ялган оношилох шинжийг сонгоно уу?
1. Хордлогын шинж гүнзгий илэрнэ
 2. Халдварын шинж илэрнэ
 3. Лейкоцитури
 4. Бактериури
 5. Шээсээр давс ялгарна
- /56./ Пиелонефритийн үед хэрэглэх антибиотیکیн зөв тунг сонгоно уу?
1. Цефотаксим 75-100 мг/кг
 2. Гентамицин 2-7.5 мг/кг
 3. Ампициллин 50-150 мг/кг
 4. Левофлоксацин 250-500 мг/кг
 5. Ципринол 200-400 мг/кг
- /57./ Цочмог ГН-ийн үед шээсний талаас ямар өөрчлөлтүүд гарах вэ?
1. Олигоури
 2. Гематури
 3. Протейнури
 4. Пиури
 5. Шээсний нягт багасна
- /58./ Даралт ихсэх хэлбэрийн архаг ГН-ийг ямар өвчнүүдээс ялган оношилох вэ?
1. Бөөрний амилоидоз
 2. Артерийн эссенциаль гипертенз
 3. Судасны цусархаг үрэвсэл
 4. Бөөрний судасны гаралтай АД ихсэлт
 5. Элэгний хатуурал
- /59./ Шалтгаан тодорхойгүй удаан халуурсан хүүхдэд хамгийн түрүүнд ямар шинжилгээ хийх вэ?
1. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
 2. Шээсний ерөнхий шинжилгээ
 3. Ц-урвалжит уураг
 4. Биохимийн шинжилгээ
 5. Коагулограмма
- /60./ Архаг ГН-ийн эмчилгээний үндсэн зарчим
1. Дархлаа эмгэг урвалыг дарангуйлах
 2. Түүдгэнцэр дэх үрэвслийг намдаах
 3. Түүдгэнцрийн хялгасан судасны цусны эргэлтийг хадгалах
 4. Бөөрний эдийн сорвижилтыг багасгах
 5. Артерийн даралтыг хэвийн хэмжээнд барих
- /61./ Пиелонефритийн үндсэн хамшинжид аль нь орох вэ?
1. Өвдөлтийн хамшинж
 2. Дизурийн хамшинж
 3. Хордлогын хамшинж
 4. Цусархагшлын хамшинж
 5. Хавагнах хамшинж
- /62./ Шинж тэмдэггүй бактериури нь:
1. Шээсэнд бактери илэрнэ
 2. Охидод элбэг
 3. Эмнэлзүйн шинж илрэхгүй
 4. Нас ахихын хирээр тохиолдлын тоо буурна
 5. Бөөрний архаг дутагдал үүсгэнэ
- /63./ Цочмог гломерулонефритийн үед цусны уургийн хэмжээ хэрхэн өөрчлөгдөх вэ?
1. Гаммаглобулин ихэснэ
 2. В-глобулин ихэснэ
 3. Гиперпротейнеми

4. Гипопротейнеми
 5. Глобулин, уураг хоёул буурах
- /64./ Цочмог гломерулонефритийг бөөрний үйл ажиллагааны байдлаар нь хэрхэн ангилдаг вэ?
1. Бөөрний үйл алдагдаагүй
 2. Бөөрний үйл алдагдсан
 3. Бөөрний цочмог дутагдал
 4. Бөөрний үйл бага зэрэг алдагдсан
 5. Бөөрний архаг дутагдал
- /65./ Рахитын ид үед яс зөөлөрснийг илтгэх шинжүүдийг заана уу?
1. Краниотабес
 2. Дагз хавтгайрах
 3. Брахицефали
 4. Сувдан хэлхээ
 5. Сампингийн эрхийн шинж
- /66./ Архаг ГН-ийн эмгэгжамын урвалууд аль нь вэ?
1. Цусанд гадны эсрэгтөрөгч ихээр орох
 2. Дархлаа тогтолцооны хямрал
 3. Бөөрний эсрэгтөрөгчийн генетикийн өөрчлөлт
 4. Эсийн дархлааны эмгэг өөрчлөлт
 5. Хавсрага C4, C5 ихсэх
- /67./ Шээс дамжуулах доод замын халдварт аль нь орох вэ?
1. Пиелонефрит
 2. Уретрит
 3. Гломерулонефрит
 4. Цистит
 5. Тубулопати
- /68./ Холимог хэлбэрийн АГН-ийн эмчилгээний зарчим
1. Цитостатик
 2. Антикоагулянт
 3. Антиагрегант
 4. Шээс хөөх эм
 5. Кортикостероид
- /69./ Нярай хүүхдийн пиелонефритийг оношлоход төөрөгдүүлдэг шинжүүдийг сонгоно уу?
1. Ерөнхий хордлогын шинж тод илэрнэ
 2. Халуурахгүй байж болно
 3. Аддисын шинжилгээ хэвийн байж болно
 4. Эхний өдрүүдэд бактериури сөрөг байж болно
 5. Зимницкийн шинжилгээ хэвийн байна
- /70./ Түргэн даамжрах ГН-ийн дархлалын эмгэгжамын ангилалд багтах хэлбэрүүдийг сонгоно уу
1. Бөөрний суурь хальсны эсрэг бөөрний түүдгэнцэр дэх эсрэг биеийн хуримтлал бүхий
 2. Бөөрний түүдгэнцрийн мөхлөгт дархан бүрдэл бүхий
 3. Түүдгэнцрийн дархлалын бага зэргийн бөөгнөрөлтэй болон бөөгнөрөлгүй
 4. Түүдгэнцэрт мезанги эсийн олшрол
 5. Түүдгэнцрийн үл мэдэг өөрчлөлт
- /71./ Цочмог ГН-ийн үед илрэх протейнурийн онцлог
1. Хоногийн шээсэнд уураг 3.5 г/л-ээс ихгүй
 2. Шээсээр сонгомол хэлбэрийн уураг ялгарна
 3. Шээсээр ихэвчлэн альбумин ялгарна
 4. Шээсээр ихэвчлэн 85000-аас их масстай уураг ялгарна
 5. Протейнури 2 долоо хоногоос удаан үргэлжилнэ.
- /72./ Хүүхдэд АД хэвийн хэмжээнээс хэдэн мм.муб-аар нэмэгдэхэд даралт ихэссэн гэж үзэх вэ?
1. 10
 2. 20

3. 30

4. 40

5. 50

/73./ Цитостатик эмийн ГН-ийн үед үзүүлэх гаж нөлөө

1. Лейкопени
2. Тромбоцитопени
3. Биед буй халдварт голомтууд идэвхжих
4. Анеми
5. Цусан дахь уураг багасах

/74./ 10 настай хүү халуурна, залгихад хоолой хөндүүрлэнэ, хар цай шиг хүрэн өнгөтэй шээсэн. Энэ өвчин анх удаа тохиолдож байна. Ямар өвчин байх магадлал өндөр вэ? Ямар шинжилгээ шаардлагатай, илүү тодорхой мэдээлэл өгөх вэ?

1. Цочмог пиелонефрит
2. Цочмог гломерулонефрит
3. Шээсний нян судлалын шинжилгээ
4. Шээсний ерөнхий шинжилгээ
5. Хоногийн шээсэнд биохими

/75./ Пиелонефритийн үед ямар үйлчилгээтэй антибиотикийг сонгох вэ?

1. Грам эерэг нянгийн эсрэг
2. Бактерцид
3. Грам сөрөг нянгийн эсрэг
4. Өргөн хүрээний үйлчилгээтэй
5. Бактериостатик үйлчилгээтэй

/76./ Р шилбүүртэй эмгэгтөрөгч нь бөөр шээсний замын аль эмгэгийг үүсгэх вэ?

1. Интерстициальный нефрит
2. Пиелонефрит
3. Тубулопати
4. Цистит
5. Бөөрний амилоидоз

/77./ Бага насны хүүхдэд бөөр-шээсний замын халдвар үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл:

1. Энтеробиоз
2. Гаж хөгжил
3. Давсагны үйл ажиллагаа алдагдах
4. Баасан дээрээ удаан хэвтэх
5. Хөвгүүдийн тээрхийн нарийсал

/78./ Гломерулонефритийн үед минерал кортикоид-альдостероны үүсэлт хэрхэн идэвхждэг вэ?

1. Түүдгэнцрийн судасны анхдагч агчил болно
2. Бие махбодод ус баригдаж шээс багасна
3. Том судаснуудын баропрессорт үйлчилнэ
4. Эсийн гаднах шингэн ихэснэ
5. Цусанд кали ихэснэ

/79./ 10 настай хүүд өөрт илрэх зовуургүй боловч шинжилгээгээр микрогематури, бага зэргийн протейнури илрээд 3 жил болж байна. Гематурийн хэмжээ үе үе ихэсдэг. Урьдчилсан оношийг сонгоно уу.

1. Архаг ГН-ийн нефроз хэлбэр
2. Архаг ГН-ийн гематурийн хэлбэр
3. Архаг ГН-ийн холимог хэлбэр
4. Иммуноглобулин А нефропати
5. Пиелонефрит

/80./ Цочмог гломерулонефритийг үе шатаар хэрхэн ангилдаг вэ?

1. Эхний илрэл
2. Эдгэрэх
3. Архагт шилжих
4. Хагас намжилт
5. Эмнэлзүй, лабораторийн бүрэн намжилт

/81./ Рахитын эхлэл үе ямар шинж тэмдгээр илрэх вэ?

1. Анхны шинж тэмдэг 1-1.5 сартай илэрч болно
2. Нойр хоолонд сайнгүй болох
3. Гэрэл асах, дуу чимээ гарахад цочиж сэрэх
4. Хөхөө хөхөхдөө хөлрөх
5. Шээс хурц үнэртэй болох

/82./ Индометацин нь бөөрний үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг тул архаг ГН-ийн эмчилгээнд харьцангуй бага хэрэглэдэг.

/83./ Тураалтай нэгээс дээш насны хүүхдэд өгөх А-аминдэмийн нэг удаагийн тун ямар байх вэ?

- A. 10000 ME
- B. 50000 ME
- C. 100000 ME
- D. 200000 ME
- E. 300000 ME

/84./ 13 настай хүүхдийн гемоглобинд агуулагдах төмөр нийт төмрийн хэдэн хувийг эзлэх вэ?

- A. 55
- B. 70
- C. 72
- D. 73
- E. 79

/85./ 1 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

- A. 242 мг
- B. 122 мг
- C. 400 мг
- D. 600 мг
- E. 2600 мг

/86./ Төмөр дутлын цус багадалтын үед ферритиний хэмжээ хэдээс доош байх вэ?

- A. 10 нг/мл
- B. 20 нг/мл
- C. 30 нг/мл
- D. 40 нг/мл
- E. 50 нг/мл

/87./ Хоол хүнсэн дэх төмрийн хэдэн хувь нь шимэгддэг вэ?

- A. 1
- B. 2
- C. 10
- D. 15
- E. 20

/88./ Тураалын I зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?

- A. 110-130 ккал/кг
- B. 100-95 ккал/кг
- C. 90-85 ккал/кг
- D. 80-65 ккал/кг
- E. 60-50 ккал/кг

/89./ 1 мл цус алдахад хэдэн мг гемоглобин хорогдох вэ?

- A. 0.5
- B. 3.4
- C. 5
- D. 12
- E. 30

/90./ Тураалтай 6 сар хүрээгүй хүүхдэд өгөх А-аминдэмийн нэг удаагийн тун ямар байх вэ?

- A. 10000 ME
- B. 50000 ME
- C. 100000 ME
- D. 200000 ME

- E. 300000 ME
- /91./ 1 настай хүүхдийн гемоглобинд агуулагдах төмөр нийт төмрийн хэдэн хувийг эзлэх вэ?
- A. 55
 - B. 70
 - C. 72
 - D. 73
 - E. 79
- /92./ 1 грамм гемоглобинд хэдэн мг төмөр агуулагдах вэ?
- A. 0.2
 - B. 3.4
 - C. 5
 - D. 12
 - E. 30
- /93./ Төмөр дутлын цус багадалтын үед улаан эс дэх Hb агууламж (MCH) хэдээс доош байх вэ?
- A. 15 нг
 - B. 17 нг
 - C. 20нг
 - D. 25 нг
 - E. 27 нг
- /94./ Тураал I зэрэгтэй хүүхдийн хоолыг нэмэгдүүлэх үед илчлэгийн хэмжээ хоногт хэд байх вэ?
- A. 180-200 ккал/кг
 - B. 140-160 ккал/кг
 - C. 110-130 ккал/кг
 - D. 100-95 ккал/кг
 - E. 90-85 ккал/кг
- /95./ Тураалын II зэргийн үед жингийн алдагдал ямар байх вэ?
- A. 15-10
 - B. 21-30%
 - C. 11-20%
 - D. 32%
 - E. 10-0
- /96./ Хүнд тураалтай хүүхдэд хоногт нэмж өгөх магнийн хэмжээ хэд вэ?
- A. 0.4-0.6 ммоль/кг
 - B. 1.0-2.0 ммоль/кг
 - C. 3.0-4.0 ммоль/кг
 - D. 5.0-6.0 ммоль/кг
 - E. 7.0-8.0 ммоль/кг
- /97./ Төмөр дутлын цус багадалтын үед хүүхдэд өгөх төмрийн хэмжээ ямар байх вэ?
- A. 0.5-0.8 мг/кг
 - B. 1-2 мг/кг
 - C. 3-5 мг/кг
 - D. 6-8 мг/кг
 - E. 8-10 мг/кг
- /98./ Тураалын II зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?
- A. 110-130 ккал/кг
 - B. 100-95 ккал/кг
 - C. 90-85 ккал/кг
 - D. 80-65 ккал/кг
 - E. 60-50 ккал/кг
- /99./ Рахитын эхлэл үед хүүхдэд өгөх D-аминдэмийн тун ямар байх вэ?
- A. 500-600 ME/хоног
 - B. 100-200 ME/кг
 - C. 2000-5000 ME/хоног
 - D. 200000-400000 ME/курс

- Е. 50-100 МЕ/кг
- /100./ Тураалын II зэрэгтэй хүүхдийг хэдэн удаа хооллох вэ?
- A. 5
 - B. 6
 - C. 7
 - D. 8
 - E. 9
- /101./ Хүнд тураалтай хүүхдийн хоолонд аль нь илүү тохирох вэ?
- A. Үнээний сүү
 - B. Шингэн бантан
 - C. Хярам
 - D. Хөхний сүү
 - E. Өтгөн зутан
- /102./ Гүйцэт нярайн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?
- A. 242 мг
 - B. 122 мг
 - C. 400 мг
 - D. 600 мг
 - E. 2600 мг
- /103./ Төмөр дутлын цус багадалтын үед 6 хүртэлх насны хүүхдэд Hb хэмжээ хэдээс доош байх вэ?
- A. 100 г/л
 - B. 110 г/л
 - C. 120 г/л
 - D. 130 г/л
 - E. 140 г/л
- /104./ Хүнд тураалтай хүүхдэд нөхөн сэргээх эмчилгээг хэд хоног үргэлжлүүлэх вэ?
- A. 1-2
 - B. 3-7
 - C. 2-5
 - D. 8-15
 - E. 1 сар
- /105./ Хүнд тураалтай хүүхдэд хоногт нэмж өгөх калийн хэмжээ хэд вэ?
- A. 0.4-0.6 ммоль/кг
 - B. 1.0-2.0 ммоль/кг
 - C. 3.0-4.0 ммоль/кг
 - D. 5.0-6.0 ммоль/кг
 - E. 7.0-8.0 ммоль/кг
- /106./ Тураал II зэрэгтэй хүүхдийн хоолыг нэмэгдүүлэх үед илчлэгийн хэмжээ хоногт хэд байх вэ?
- A. 180-200 ккал/кг
 - B. 140-160 ккал/кг
 - C. 110-130 ккал/кг
 - D. 100-95 ккал/кг
 - E. 90-85 ккал/кг
- /107./ Тураалтай 6-12 сартай хүүхдэд өгөх А-аминдэмийн нэг удаагийн тун ямар байх вэ?
- A. 10000 МЕ
 - B. 50000 МЕ
 - C. 100000 МЕ
 - D. 200000 МЕ
 - E. 300000 МЕ
- /108./ 100 мл цус алдахад хэдэн грамм гемоглобин хорогдох вэ?
- A. 0.5
 - B. 3.4
 - C. 5
 - D. 12

Е. 30

/109./ 13 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

- A. 242 мг
- B. 122 мг
- C. 400 мг
- D. 600 мг
- E. 2600 мг

/110./ 5 настай хүүхдийн гемоглобинд агуулагдах төмөр нийт төмрийн хэдэн хувийг эзлэх вэ?

- A. 55
- B. 70
- C. 72
- D. 73
- E. 79

/111./ Үнээний сүүг хоногт хэдэн литрээс илүү хэрэглэхэд хүүхдэд төмрийн дутагдал үүсч болох вэ?

- A. 0.1
- B. 0.5
- C. 1.0
- D. 2.0
- E. 3.0

/112./ 2 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?

- A. 242 мг
- B. 122 мг
- C. 400 мг
- D. 600 мг
- E. 2600 мг

/113./ Төмөр дутлын цус багадалтын үед 6-аас дээш насны хүүхдэд Hb хэмжээ хэдээс доош байх вэ?

- A. 100 г/л
- B. 110 г/л
- C. 120 г/л
- D. 130 г/л
- E. 140 г/л

/114./ Төмөр дутлын цус багадалтын үед сийвэнгийн төмөр сэлбэх чадвар хэдээс дээш болох вэ?

- A. 23 мкмоль/л
- B. 43 мкмоль/л
- C. 53 мкмоль/л
- D. 63 мкмоль/л
- E. 83 мкмоль/л

/115./ Ямар үед макроцитар, гиперхром цус багадалт үүсэх вэ?

- A. Фолийн хүчлийн дутагдал
- B. B12-аминдэм дутах
- C. Төмөр дутах
- D. Уургийн дутагдал
- E. Д-аминдэмийн дутагдал

/116./ Төмөр дутлын цус багадалтын үед сийвэнгийн төмрийн хэмжээ хэдээс доош байх вэ?

- A. 4 мкмоль/л
- B. 14 мкмоль/л
- C. 24 мкмоль/л
- D. 34 мкмоль/л
- E. 10 мкмоль/л

/117./ Тураалын II зэргийн үед арьсан доорх өөхөн эд хэрхэн өөрчлөгдөх вэ?

- A. Нүүрнээс бусад хэсэгт нимгэрсэн байна
- B. Хэвлий, чээжинд арилж, мөчдөөр эрс багассан

- C. Бүх биеийн өөхөн давхарга арилна
D. Нүүр, мөчдөөр нимгэрч, бусад хэсэгт хэвийн байна
E. Нүүрэнд арилж, хэвлий чээжинд нимгэрсэн
- /118./ Тураалын I зэрэгтэй хүүхдийг хэдэн удаа хооллох вэ?
A. 5
B. 6
C. 7
D. 8
E. 9
- /119./ Тураалын III зэрэгтэй хүүхдийн хоолны илчлэг хоногт хэд байх вэ?
A. 110-130 ккал/кг
B. 100-95 ккал/кг
C. 90-85 ккал/кг
D. 80-65 ккал/кг
E. 60-50 ккал/кг
- /120./ Макролидын бүлэгт багтах антибиотик
1. Олеондомицин
2. Клиндамицин
3. Эритромицин
4. Линкомицин
5. Оксациллин
- /121./ Парацетамолын насанд тохирох тунг сонго
1. 2 сараас 12 сартай хүүхдэд 100 мг
2. 12 сараас 3 настай хүүхдэд 100-125 мг
3. 3-5 настай хүүхдэд 250 мг
4. 12 сараас 3 настай хүүхдэд 250 мг
5. 3-5 настай хүүхдэд 500 мг
- /122./ Аденоидитын үед хүүхдэд илрэх эмнэлзүйн шинж
1. Хамар байнга битүүрэх
2. Амаа ангайн их хухирч унтах
3. Доод эрүү унжих
4. Хамар-уруулын нугалаас арилах
5. Нүүр хөөнгө цэлхгэр өвөрмөц харагдах
- /123./ Грам эерэг, сөрөг нянд үйлчлэх антибиотик
1. Клавуланы хүчилтэй пенициллин
2. Цефалоспорины 1-3 үе
3. Аминогликозидууд
4. Карбопенемууд
5. Макролидууд
- /124./ Амьсгал дутлын II зэргийн үед илрэх эмнэлзүйн шинж
1. Хүүхэд тайван байхад арьс нь цонхигор, хамар-уруулын гурвалжин хөхрөх, амьсгаадах, зүрхний цохилт олшрох
2. Хүчил-суурийн тэнцвэр хүчиллэг талруугаа хэвийх
3. $pO_2=70-80$ мм.муб
4. Амьсгалын минутын эзлэхүүн 50% багасах
5. Хүчилтөрөгч эмчилгээнд үр дүнтэй
- /125./ АЦЦ (ацетилцистейн) эмийн хэрэглэх заалт
1. Гуурсан хоолойн өтгөн цэртэй архаг үрэвсэл
2. Нян, вирүсийн шалтгаантай мөгөөрсөн хоолойн үрэвсэл
3. Уушгины үрэвсэл
4. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
5. Гэмтэл ба хагалгааны дараах өтгөрсөн шүүрлийг гаргах
- /126./ Гуурсан хоолойн архаг үрэвслийн оношын шалгуур
1. Хоёр жилийн хугацаанд жилдээ 2-3 удаа сэдрэх
2. Сэдрэлийн үедээ янз бүрийн хэмжээний нойтон хэржигнүүр тогтвортой илрэх
3. 3 сар буюу түүнээс удаан хугацаагаар үргэлжлэх

4. Хүзүүний тунгалгийн булчирхай томрох
 5. "Агаарын занга" шинж илрэх
- /127./ АЦҮ-ийн үед пенициллинд тэсвэртэй үед ямар антибиотик сонгох вэ?
1. Цефаломидин
 2. Гентамицин
 3. Линкомицин
 4. Эритромицин
 5. Ампициллин
- /128./ Амьсгалын замын халдвараас хамгаалах дэглэм
1. Сайн унтуулах
 2. Цэвэр агаарт гаргах
 3. Гимнастик хийлгэх
 4. Тэжээллэг хоолоор хооллох
 5. Салст бүрхэвчийг цэвэр байлгах
- /129./ Хүүхдийн амьсгалын хэм жигд бус, гүнзгий өнгөц зэрэг тэнцвэргүй байдаг нь юутай холбоотой вэ?
1. Амьсгалын булчингийн хөгжил сул
 2. Уушгины тэнэгч мэдрэл сэргэг
 3. Амьсгалын эзлэхүүн, ашиггүй зайн хэмжээ туйлын бага
 4. Амьсгал зохицуулах төвийн хөгжил сул
 5. Чээжний хэнхэрцэг амьсгал авалтын байдалтай байх
- /130./ Чээжний үзлэгээр ямар шинжүүдийг ажиглах вэ?
1. Чээжний хэлбэр
 2. Амьсгалын хэлбэр
 3. Өнгөц венүүдийн байдал
 4. Амьсгалд чээжний 2 тал жигд оролцож байгаа эсэх
 5. Амьсгалын булчигуудын амьсгалд оролцож буй байдал
- /131./ Гуурсан хоолойн үрэвслийн онцлог шинж
1. Вирүс, нянгаар хавсарч үүсгэгдэх
 2. Бөглөршилт үрэвслийн үед бөгшүүлж ханиалгах нь илүү
 3. Ихэнх тохиолдолд бусад хамшинжүүдтэй хавсарч илрэх
 4. Өвчний эхний хоногуудад хүүхэд хуурай ширүүн, зовуурьтай бөгшүүлж ханиах
 5. Том хүүхдэд өвчүүний араар сэрвэгнэх, хорсох, халуун оргиж өвдөх
- /132./ Читамоны үйлдэл
1. Цэр ховхлох
 2. Тайвшруулах
 3. Үрэвсэл намдаах
 4. Өвчин намдаах
 5. Халуун бууруулах
- /133./ Чээжний тэмтрэх үзлэгээр юу тодорхойлох вэ ?
1. Чээжний хэнхэрцэгийн уян чанар
 2. Дууны доргио
 3. Өвдөлт
 4. Өөхөн эдийн хөгжил
 5. Арьсны зузаан
- /134./ Квинкийн байрлалын талаар зөв мэдээлэл сонго
1. Хүүхдийг доош харуулж хэвтүүлэх
 2. Хүүхдийн толгой чээжийг тонгойлгон, аарцгийн хэсгийг дээш өргөх
 3. Уг байрлалд хүүхдийг 15-20 минутын хугацаатай өдөрт 2-3 удаа байлгах
 4. Цэр ховхлох, шингэлэх бэлдмэлтэй хавсарч хэрэглэх
 5. Бөглөршилт үрэвсэлтэй хүүхдэд заавал хийх
- /135./ Аденовирүсээр үүсгэгдсэн залгиурын үрэвслийн онцлог шинж
1. Хөөмий, хүүхэн хэл, залгиурын арын хана хавагнан хөөх
 2. Залгиурын арын хана улаан, бэржгэр болох
 3. Хүзүүний арын тунгалгийн булчирхай томрох
 4. Гүйлсэн булчирхай хөөж томрох

5. Өвчин дунджаар 2 долоо хоног үргэлжлэх
- /136./ 2-6 насны хүүхдэд гүйлсэн булчирхайн үрэвслээр олонтоо өвдөх, архаг үрэвсэл үүсэх тохиолдол ихсэх нь доорх онцлогуудын алинтай нь холбоотой вэ?
1. 1 нас хүртэлх хүүхдэд гүйлсэн булчирхай, хөөмийн урд нумнаас үл харагдам байрлах
 2. 2 наснаас эхлэн гүйлсэн булчирхайн гиперплази ажиглагдах
 3. Цусны судас бага, хонхрууд бүдэг
 4. 4-10 насанд дээд хэмжээндээ хүрч томрох
 5. 14-15 насанд хэвийн хэмжээтэй болох
- /137./ Гүйлсэн булчирхайн үрэвсэл үүсгэх нянгийн гол төлөөлөгчид
1. Ротавирус
 2. Стрептококк
 3. Клебсиелл
 4. Стафилококк
 5. Энтерококк
- /138./ Нялх бага насны хүүхдийн хамрын салстын үрэвслийн үед илрэх зовуурь
1. Хамар битүүрэх
 2. Хөхөө хөхөхөд саадтай
 3. Зовуурьтай уйлагнах
 4. Амаараа амьсгах
 5. Шархирч хорсох
- /139./ Макрофены тунг нэрлэнэ үү
1. 5 кг жинтэй 2 сараас дээш 1/2 цайны халбага
 2. 10 кг жинтэй 1 хүртэлх насанд 1/2 цайны халбагаар 2 удаа
 3. 15 кг жинтэй 4 хүртэлх насанд цайны халбагаар 2 удаа
 4. 20-оос дээш кг 6 хүртэлх насанд 2 цайны халбагаар 3 удаа
 5. 30 кг-аас дээш жинтэй хүүхдэд 1/2 цайны халбагаар 2 удаа
- /140./ Антибиотик эмчилгээний үед хавсарч хэрэглэхэд үр дүнтэй эмүүд
1. С-аминдэм
 2. В1-аминдэм
 3. В2-аминдэм
 4. Лактобактери
 5. Интерферон
- /141./ Мөгөөрсөн хоолойн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинж
1. 1. Томуугийн халдварын үед ихэвчлэн илрэх
 2. Эхний хоногуудад хуурай бөгшүүлж ханиалгах
 3. 3. Өвчүүний ард, чээж хорсож, зүсэгдэж буй мэт өвдөх
 4. Уушги чагнахад амьсгал ширүүн, хуурай эсвэл том хөөслөг цэврүүт нойтон хэржигнүүр сонсогдох
 5. Рентген шинжилгээнд уушгины уг ялимгүй өргөсөх
- /142./ Салсархаг шүүрлийг шингэрүүлэх бэлдмэл
1. Мукалтин
 2. Шүлтлэг рашаан
 3. Алтайн үндэс
 4. 2%-ийн содын уусмал
 5. Тарваган шийрийн ханд
- /143./ Аденовирусээр үүсгэгдсэн залгиурын үрэвслийн онцлог шинж
1. Хөөмий, хүүхэн хэл, залгиурын арын хана хавагнан хөөх
 2. Залгиурын арын хана улаан, бэржгэр болох
 3. Хүзүүний арын тунгалгийн булчирхай томрох
 4. Гүйлсэн булчирхай хөөж томрох
 5. Өвчин дунджаар 2 долоо хоног үргэлжлэх
- /144./ Бага насны хүүхдийн хамраас цус гоожих нь ховор байдаг юутай холбоотой вэ?
1. Доод жим байдаггүй
 2. 2 нас хүртэлх хүүхдэд хамрын дайвар хөндий үүсгэвэр төдий буюу огт байдаггүй
 3. Хамрын венийн хялгасан судас гавлын хөндийн тууш вентэй холбогдсон
 4. Хамрын хөндийн доод хэсгийн салст бүрхэвчийн судаслаг эдийн хөгжил дутмаг

5. Хоногт 0.5-1 л салст ялгаруулах
- /145./ Амьсгалын эрхтнийг шинжлэн судлах аргууд
1. Асуумж
 2. Бодит үзлэг
 3. Лаборатор
 4. Дуран
 5. Рентген шинжилгээ
- /146./ Шуугиантай амьсгалтай уушгины хатгалгаа гэж ангилсан тохиолдолд эмчилгээг тогтоо
1. Үүсгэгчийн эсрэг эмийг 3-5 хоног өгөх
 2. гуурс тэлэгч эм өгөх
 3. хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт, ханиалга эмчлэх
 4. 2 хоноод давтан үзүүлэх
 5. эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх
- /147./ Цефалоспорины бүлгийн антибиотик
1. Цефоперазон
 2. Цефотам
 3. Цефотриаксон
 4. Цефатазидим
 5. Цефотаксим
- /148./ Амьсгалын дутлын I зэргийн үед илрэх эмнэлзүйн шинж
1. Хүүхэд тайван үед эмгэг шинж илрэхгүй.
 2. Ачаалал нэмэгдэхэд зүрхний цохилт олшрох, амьсгаадах, хамар-уруулын гурвалжин хөхрөх
 3. $pO_2 = 80-90$ мм.м.у.б
 4. Амьсгалын минутын эзлэхүүн ихсэх
 5. Хүүхэд байж ядсан байдалтай байх
- /149./ Хүүхэд уух буюу хөхөх чадвартай эсэхийг эхээс асуухад эргэлзээтэй санагдвал юу хийх ёстой вэ?
1. Эхээс хэдийнээс эхлээд хөхөж чадахгүй байгааг тодруулж асуух
 2. Хүүхдийн хамрыг цэвэрлэх
 3. Хүүхэд өгсөн шингэнийг залгиж чадаж байсан эсэхийг асуух
 4. Хүүхдэд шингэн буюу хөхний сүү өгөөд залгиж чадаж буй эсэхийг ажиглах
 5. Асуусан асуултыг эх ойлгосон эсэхийг шалгах
- /150./ Читамон хэрэглэх заалт
1. Ханиад томуу
 2. Гуурсан хоолойн цочмог, архаг үрэвсэл
 3. Уушгины хатуурал
 4. Уушги тэлэх өвчин
 5. Цагаан мөгөөрсөн хоолойн цочмог үрэвсэл
- /151./ Хүүхэд амьсгалахад харьцангуй их хүч зарцуулах нь ямар шалтгаантай вэ?
1. Амьсгалын эзлэхүүн, ашиггүй зайн хэмжээ туйлын бага
 2. Амьсгал зохицуулах төвийн хөгжил сул
 3. Хавирга зөөлөн, чээжний хэнхэрцэг их уян
 4. Уушгины уян эдийн хэмжээ бага
 5. Чээжний хэнхэрцэг амьсгал авалтын байдалтай
- /152./ Холимог амьсгаадалт ямар үед үүсэх вэ ?
1. Чээжний гялтан хальсны үрэвсэл
 2. Цусны бага эргэлтийн зогсонгишил
 3. Гэдэс дүүрэх
 4. Хэвлийн хөндийд шингэн хуралдах
 5. Хүнд сульдаатай хүүхдэд
- /153./ Хүнд халдвар, хордлогын үед амьсгалын дутагдал үүсэх шалтгаан
1. Зүрхний булчингийн үрэвсэл
 2. Эсийн эсгэгийн тогтолцоо хямрах
 3. Зүрхний үнхэлцгэн хальсны үрэвсэл
 4. Эд, эс хүчилтөрөгч үл шингээх

5. Чээжний гялтангийн хөндийд шингэн хуралдах
- /154./ Стрептококкоор үүсгэгдсэн залгиурын үрэвслийн ялгагдах шинж
1. Тунгалгийн булчирхай томорч хөндүүрлэх
 2. Гүйлсэн булчирхай хавагнан улайж сүвүүдэд идээ тогтох
 3. 390С-аас өндөр халуурч хоолой хүчтэй өвдөх
 4. Залгиурын салст хуурайших
 5. Хамраас салсархаг нус гоожих
- /155./ АЦХ-тай халуунтай хүүхдэд өгөх зөвлөгөө
1. 38.50С хүртэлх халуунтай үед шингэн илүү уулгах
 2. 38.50С дээш халуурвал парацетамол тохирсон тунгаар 6 цагийн зайтай халуун буутал хэрэглэх
 3. Хөл гарыг чийгтэй алчуураар арчих
 4. 380С хүрмэгц парацетамол өгөх
 5. Үүсгэгчийн эсрэг эмийн бэлдмэл өгөх
- /156./ Амьсгалын гаралтай гипоксийн үед доорх өөрчлөлтүүдээс аль нь илрэх вэ?
1. Уушгины агааржилт буурах
 2. Алвеоль капиллярын мембранаар хийн нэвчилт багасах
 3. Уушгины цусан хангамж багасах
 4. Агааржилт цусан хангамжийн хэвийн харьцаа өөрчлөгдөх
 5. Эргэлдэх цусны эзлэхүүн багасах
- /157./ Хуурай исгэрсэн хэржигнүүр ямар эмгэгүүдийн үед сонсогдох вэ?
1. Залгиур, мөгөөрсөн хоолойн үрэвсэл
 2. Гуурсан хоолойн багтраа
 3. Уушгины үрэвсэл
 4. Гуурсан хоолойн бөглөршилт үрэвсэл
 5. Уушгины нэвчдэст үрэвсэл
- /158./ Ерөнхий үзлэгээр үнэлэх шинж
1. Биеийн ерөнхий байдал
 2. Царайны илрэл
 3. Арьсны өнгө
 4. Биеийн байрлал
 5. Ухаан санааны байдал
- /159./ Ханиалгах, чээжээр өвдөх шинж нь амьсгалын эрхтний ямар эмгэгийн үед элбэг тохиолдох вэ?
1. Харшлын эмгэг
 2. Гуурсан хоолойн багтраа
 3. Уушгины гялтан хальсны үрэвсэл
 4. Сүрьеэ өвчин
 5. Чээжний хөндийн тунгалгийн булчирхай томрох
- /160./ АЦХ-ын үед үүсгэгчийн эсрэг эм хэрэглэх заалт
1. Хордлогын шинж тод илрэх
 2. 5 хоног дараалан халуурах
 3. Цэр буюу салс идээрхэг
 4. Гуурс бөглөршил, гуурсанцарын үрэвслийн шинж илрэх
 5. Үүсгэгч микоплазм, хламид сэжигтэй байх
- /161./ Төвөнх, мөгөөрсөн хоолой, гуурсны цочмог үрэвслийг байршлаар нь хэрхэн ангилдаг вэ?
1. Эпиглотит
 2. Төвөнх-мөгөөрсөн хоолойн
 3. Төвөнх-мөгөөрсөн хоолой-гуурсны
 4. Төвөнх-уушгины
 5. Төвөнх-гүйлсэн булчирхайн
- /162./ Хүүхдийн амьсгалыг зөв тоолохын тулд юуг анхаарах ёстой вэ?
1. Хүүхдийн чээж-хэвлийн хэсгийг ил гаргах
 2. Нэг минутын турш тоолох
 3. Хэрэв тоолсон тоондоо эргэлзэж байвал дахин тоолох

4. Хүүхдийг тайван уйлаагүй үед тоолох
 5. Хүүхэд тайван бус байвал эхээс хүүхдийг тайвшруулахыг хүсэх
- /163./ Грам сөрөг нянд нөлөөлөх антибиотик
1. Тобромицин
 2. Амикацин
 3. Левомицитин
 4. Цефуросим
 5. Метранидазол
- /164./ Гуурсан хоолойн үрэвслийн үед рентген шинжилгээнд гарах өөрчлөлт
1. Уушгины уг хэсгээр нэвчдэст сүүдэр
 2. Уушгины угийн сүүдэр ялимгүй өргөсч, уушгины зураглал тодрох
 3. 2 далны хооронд голомтот сүүдэр
 4. Амьсгалын гуурс цэрээр бөглөрснөөс авчилз
 5. Баруун уушгины доод хэсэгт нэвчдэст сүүдэр
- /165./ АЦХ-ын эмгэгжамын эмчилгээ
1. Хордлого тайлах
 2. Хямарсан эрхтнүүдийн үйл ажиллагааг сэргээх
 3. Бүтцийн эмгэг өөрчлөлтийг зогсоох
 4. Биеийн дархлал урвалыг идэвхжүүлэх
 5. Ерөнхий эсэргүүцлийг сайжруулах
- /166./ Уушгины хатгалгаагүй ханиад шуухинаа гэж ангилсан 4 сартай хүүхдэд ямар зөвлөгөө өгөх вэ?
1. 30-аас олон хоног ханиалгасан бол онош тодруулахаар эмнэлэгт хэвтүүлэх
 2. Хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт, ханиалгыг эмчилэх
 3. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлөх
 4. Хэрэв сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүлэх
 5. А-аминдэм өгөх
- /167./ Цэр шингэлэх үйлчилгээтэй бэлдмэлийн ангилал
1. Уураг задлагч фермент
 2. Мукорегулятор
 3. Цистейны бүлэг
 4. Рефлексийн замаар үйлчлэх
 5. Шимэгдүүлэх үйлчилгээ үзүүлэх
- /168./ Амьсгалын цочмог халдварын үед бага насны хүүхдийн хамрын салст хөөж хавагнахын шалтгаан нь юу вэ?
1. Хамар жижигхэн богинохон
 2. Салст бүрхэвч хөвсгөр
 3. Хамрын хөндий нарийхан
 4. Тунгалгийн болон цусны судсаар баялаг
 5. Доод жим байдаггүй
- /169./ Рестриктив (хязгаарлагдмал) амьсгалын дутагдал үүсэх шалтгаан
1. Уушги тоосжих
 2. Гялтангийн хөндийд хий, шингэн хуралдах
 3. Цусны эргэлтийн архаг дутагдал
 4. Гуурсан хоолойн хавхлагат бөглөршил
 5. Амьсгалын зам гадны биетээр бөглөрөх
- /170./ Хагас нийлэг пенициллины бүлэгт орох антибиотик
1. Амоксациллин
 2. Нафциллин
 3. Тетрациклин
 4. Карбопенемин
 5. Линкомицин
- /171./ АЦХ-тай хүүхдэд халуун бууруулах эмчилгээг хэдийд хийх вэ?
1. Халуурах нь биеийн хамгаалах урвал учраас эмчилгээ хийхгүй
 2. Хүүхдийн халуун 38.50C-аас дээш үед
 3. Субфебрил халууралттай үед

4. Халуурахаараа татдаг гэсэн өгүүлэмжтэй
 5. Халуунтай нярай хүүхэд
- /172./ Амброкс-денкыг хэрэглэх заалт
1. Ханиалга
 2. Хамрын үрэвсэл
 3. Гуурсан хоолой хөөж хавагнах
 4. Өтгөн цэртэй байх
 5. Гуурсан хоолой агчих
- /173./ Бага насны хүүхдийн амьсгалын эзлэхүүн буурахад нөлөөлдөг хүчин зүйл
1. Хүүхдийн гэдэс дүүрэх
 2. Элэг томрох
 3. Хэт хооллох
 4. Уушгины тэнэгч мэдрэл сэргэг
 5. Амьсгал зохицуулах төвийн хөгжил сул
- /174./ Амьсгал гаргах саадтай байдал ямар үед үүсэх вэ ?
1. Гуурсан хоолойн булчин агших
 2. Гуурсан хоолойд цэр хуримтлагдах
 3. Гуурсан хоолойн салс хөөж хавагнах
 4. Гуурсан хоолойн багтрааны үед
 5. Төвөнхийн үрэвсэл
- /175./ Томуугийн вирүсээр үүсгэгдсэн залгиурын үрэвслийн онцлог шинж
1. Залгиурын арын хана, хүүхэн хэлний уг, зөөлөн тагнайн судсууд өргөсөх
 2. Хатуу, зөөлөн тагнай, залгиурын арын хананы салст бүрхэвчинд жижиг, цэгчилсэн цус харвалт гарах
 3. Ерөнхий хордлогын шинж тод илрэх
 4. Төвөнхийн үрэвсэлтэй хавсарч явагдах
 5. 390С-аас өндөр халуурч хоолой хүчтэй өвдөх
- /176./ Эдийн хүчилтөрөгч шингээх чадвар алдагдах шалтгаан
1. Амьсгалын ферментийн идэвх буурах
 2. Амьсгалын ферментийн нийлэгжилт саатах
 3. Биологийн эсийн мембраны бүтэц алдагдах
 4. Агаарын найрлага дахь хүчилтөрөгчийн хэмжээ багасах
 5. Уушгины агааржилт цусны эргэлтийн хэвийн харьцаа алдагдах
- /177./ Грам эерэг нянд нөлөөлөх антибиотик
1. Эритромицин
 2. Цефаломидин
 3. Ампициллин
 4. Цефалоспорин
 5. Тетрациклин
- /178./ Гуурсан хоолойн амьсгал ямар үед сонсогдох вэ?
1. Уушгинд авчилз үүсэхэд
 2. Эрүүл хүүхдийн төвөнх, мөгөөрсөн хоолой дээр
 3. Уушгины эд хатуурах
 4. Уушгины нэвчдэст үрэвсэл, буглаатай үед
 5. Гялтан хальс зузаарах
- /179./ АЦХ-тай хүүхдийг гэрээр эмчлэх эмийн бус эмчилгээний арга
1. Эрээн булчин, чээжинд гич наах
 2. Чээжинд гич буюу бумба тавих
 3. Гичтэй бүлээн усанд хөлийг дүрэх
 4. Тарваган шийртэй сүү уулгах
 5. Алтайн үндэс, аньсны навч хандалж уулгах
- /180./ Амьдралын түүхээс тодруулж асуух зүйл
1. Амьсгалын эрхтний эмгэгээр өвчлөхөд нөлөөлөх урьдал хүчин зүйлүүд
 2. Хооллолт
 3. Амьдарлын нөхцөл, орчны эрүүл ахуй
 4. Урьд өвчилсөн халдварт болон халдварт бус өвчин

5. Товлолын дагуу вакцинд хамрагдсан эсэх
- /181./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинж
1. Гүйлсэн булчирхай хөөж томрох
 2. Салстын өнгө улайж хүрэгтэх
 3. Булчирхайн хонхруудад идээ хурах
 4. Архаг үрэвслийн үед гүйлсэн булчирхай сорвижиж хатуурах
 5. Зөөлөн тагнайн хажуу ирмэгтэй наалдах
- /182./ Сальбутамолын гаж нөлөө
1. Судасны лугшилт олшрох
 2. Зүрх дэлсэх
 3. Гар чичрэх
 4. Ам хатах
 5. Биеэр тууралт гарах
- /183./ Харах үзлэгээр төвөнхийн үрэвсэлтэй хүүхдэд илрэх шинж
1. Хүүхдийн царай цонхийж цайх
 2. Хамар-уруул орчмоор хөхөлбий туяатай
 3. Зовуурьтай шаналангуй
 4. Амьсгал авах үед туслах булчингийн оролцоо ихсэх
 5. Хяхатнасан амьсгал зайнаас сонсогдох
- /184./ Бензилпенициллины гаж нөлөө
1. Бөөр гэмтэх
 2. Харшлын урвал
 3. Ходоод гэдэсний үйл хямрах
 4. Арьсаар тууралт гарах
 5. Мэдрэл гэмтэх
- /185./ Ханиалга намдаах төвийн үйлдэлтэй эм
1. Либексин
 2. Кодейн
 3. Балтикс
 4. Этилморфин
 5. Абехол
- /186./ Котримоксазолын гаж нөлөө
1. Арьсаар тууралт гарах
 2. Стивенс-Джонсоны хамшинж
 3. Ялтсан эс цөөрөх
 4. Нейтропил цөөрөх
 5. Дүлийрэх
- /187./ Гуурсан хоолойн үрэвслийн үед ямар хэрчигнүүр сонсогдох вэ?
1. Тархмал хуурай хэрчигнүүр
 2. 2 уушгинд тархмал исгэрсэн хуурай хэрчигнүүр
 3. Тархмал нойтон хэрчигнүүр
 4. Шүүрэл ихэссэн үед том, дунд хөөслөг хэрчигнүүр
 5. Шаржигнуур
- /188./ Бромгексин хэрэглэх заалт
1. Ховхроход бэрхшээлтэй өтгөн цэртэй мөгөөрс-гуурсан хоолойн үрэвсэл
 2. Архаг бронхит
 3. Гуурсан хоолойн багтраа
 4. Муковисцидоз
 5. Уушгины үрэвсэл
- /189./ Дунд хэлтэнгийн хам шинж үүсэх шалтгаан
1. Уушгины үрэвсэл ихэвчлэн доод дэлбэнгийн 6, 10-р, дээд дэлбэнгийн 2-р хэлтэнд байрлах
 2. Чээжний гялтан нимгэн, гадна гялтан муу бэхлэгдсэн байх
 3. Хавирга зөөлөн, чээжний хэнхэрцэг их уян байх
 4. Үрэвслийн шалтгаанаар уушгины угт байрлах тунгалгийн булчирхай томрох
 5. Өрц сул агшиж, амьсгал өнгөц байх

/190./ Рефлексийн замаар цэр ховхлох эм

1. Ацетилцистейн
2. Карбоцистейн
3. Бромгексин
4. Чигатуссин
5. Амброксол

/191./ Амьсгал авах саадтай байдал ямар үед үүсэх вэ ?

1. Гуурсан хоолойн булчин агших
2. Төвөнхийн үрэвсэл
3. Хамрын салст хөөж хавагнах
4. Гадны биет залгих
5. Гуурсан хоолойн багтрааны сэдрэлийн үед

/192./ Бөглөршилт амьсгалын дутагдал үүсэх шалтгаан

1. Амьсгалын замд гадны биет орох
2. Амьсгалын гуурс, гуурсанцар агчих
3. Амьсгалын гуурс цэрээр бөглөрөх
4. Агаар дах хүчилтөрөгчийн парциаль даралт буурах
5. Уушгины эд, эс соривжин хатангирших

/193./ АЦХ-тай хүүхдийг гэрээр асрахдаа анхаарах зүйлс

1. Сайн хооллох
2. Шингэн их уулгах
3. Хүүхдийг хэт бэгнэхгүй байх
4. Хооллохын өмнө хамрыг заавал цэвэрлэх
5. 6 сар хүрээгүй хөхүүл хүүхдийг тураалаас сэргийлж эрт хоолонд оруулах

/194./ Дараах эмгэгүүдийн алинд нь тогшилтын чимээ бүдгэрч өөрчлөгдөх вэ?

1. Уушгины агааржилт ихсэх
2. Уушгинд авчилз үүсэх
3. Гялтанд хий хуралдах
4. Тунгалгийн булчирхай томорох
5. Гуурсан хоолойн бөглөршил

/195./ Муколизины давуу тал

1. Агаарын урсгалын эсэргүүцлийг бууруулах
2. Амьсгал гаргалтыг дэмжих
3. Хуурай ханиалганд илүү үр дүнтэй
4. Уушгины цусан хангамжийг сайжруулах
5. Дархлаа сайжруулж, цэр ховхлох

/196./ Чээжний гялтангийн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинжүүд

1. Ханиахад өвдөлт багасах
2. Чээжийг дарах, өвчтэй талаараа хэвтэхэд багасах
3. Эмгэгтэй талруу бөхийхөд өвдөлт ихсэх
4. Амьсгал авах, гаргахад өвдөх
5. Амьсгал авалт саадтай болох

/197./ Өвчний түүхээс тодруулж асуух зүйл

1. Өвчин хэдийд яаж эхэлсэн тухай
2. Өвчин үүсэхэд нөлөөлсөн таагүй хүчин зүйл
3. Өвчний явц
4. Эмчилгээ хийсэн эсэх, үр дүн
5. Өсөлт хөгжилт хэвийн явагдсан эсэх

/198./ Сальбутамолын үйлчлэх механизм

1. Умай, зүрхнээс бусад эрхтний гөлгөр булчингийн α -рецепторыг идэвхжүүлэх
2. Захын судсыг тэлэх
3. Сулралтын даралт бууруулах
4. β -адреносаатуулагчийн эсрэг үйлдэлтэй
5. Гуурсан хоолойн гилгэр булчинг сулруулах

/199./ Ханиалга намдаах бэлдмэлийг үйлчлэх механизмаар нь хэрхэн ангилах вэ?

1. Төвийн үйлдэлтэй

2. Захын үйлдэлтэй
 3. Хавсарсан үйлдэлтэй
 4. Ханиалга сэдээх
 5. Ханиалга дарангуйлах
- /200./ Гүйлсэн булчирхайн архаг үрэвслийн үеийн эмчилгээний ерөнхий зарчим
1. Хүүхдийг чийрэгжүүлэх, аминдэмжүүлэх, сайн хооллох
 2. Ерөнхий ба хэсэг газрын дархлаа сулруулах нөлөөллөөс зайлсхийх
 3. Үүсгэгчийн эсрэг антибиотик эмчилгээ
 4. Хордлого тайлах эмчилгээ
 5. Хэсэг газрын эмчилгээ
- /201./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед ахлах насны хүүхдэд илрэх зовуурь
1. Хоолой торох, юм залгихад хөндүүрлэх,
 2. Үе мөчөөр өвдөх
 3. Зүрхээр хөндүүрлэх
 4. Хуурай ханиах
 5. Хамар битүүрэх
- /202./ Цэр шингэлэх уураг задлагч фермент
1. Панкипсин
 2. Химопсин
 3. Трипсин
 4. Химотрипсин
 5. Мукалтин
- /203./ Төвөнх мөгөөрсөн хоолойн цочмог нарийсалт үрэвсэл үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл
1. Сульдаа
 2. Шүүдэст гаж байдал
 3. Хөөнгө мариа
 4. Аминдэм дутал
 5. Улирлын байдал
- /204./ Шимэгчийн халдварын үед хэрэглэх эм
1. Хлорамфеникол
 2. Амикацин
 3. Цефуросин
 4. Метранидазол
 5. Линкомицин
- /205./ Бактериостатик үйлчилгээтэй антибиотик
1. Тетрациклин
 2. Хлорамфеникол
 3. Линкомицин
 4. Фузидин
 5. Аминогликозид
- /206./ АЦХ-тай хүүхдийг гэрээр эмчлэх үед ажиглах шинжүүд
1. Амьсгал саадтай болох
 2. Амьсгалын тоо олшрох
 3. Хүүхдийн зовуурь шаналгаа ихсэх
 4. Хүүхдийн цэр ховхролт
 5. Шингэн уух байдал
- /207./ Гуурсан хоолойн үрэвслийн үед өгүүлэх зовуурь
1. АЦХ-ын шинж бүхий зовуурь хэлэх
 2. Бага насны хүүхэд ханиалгах үед зовуурьтай уйлагнах
 3. Чээж нь шуугиж бөгшүүлж ханиалгах
 4. Том насны хүүхэд чээжээр хорсож өвдөх
 5. Ахлах насны хүүхэд хүчтэй ханиаснаас хэвлийн булчингаар өвдөх
- /208./ Муколизин хэрэглэх заалт
1. Гуурсан хоолойн үрэвсэл
 2. Цэр ховхрохгүй байгаа гуурсан хоолойн багтраа
 3. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин

4. Харшлын гаралтай хоолой сэрвэгнэж ханиах
 5. Хамрын үрэвсэл
- /209./ Уушгины хөгжлийн II үе 2-5 насанд бүтцийн ямар өөрчлөлтүүд явагддаг вэ?
1. Уушгины уян эд эрчимтэй хөгжих
 2. Гуурсан хоолойн эргэн тойрны эд эрчимтэй хөгжих
 3. Тунгалгийн булчирхай эрчимтэй хөгжих
 4. Ацинусын хөгжил гүйцэд хөгжих
 5. Уушгины жин нэмэгдэх
- /210./ Гуурс тэлэгч эмүүдийг нэрлэ
1. Сальбутамол
 2. Адреналин
 3. Аминофиллин
 4. Пипольфен
 5. Супрастин
- /211./ Амьсгалын дутагдлын IV зэргийн үед илрэх эмнэлзүйн шинж
1. Хүүхэд ухаангүй
 2. Амьсгал өнгөц, хэм алдагдах
 3. Тархмал хөхрөлт
 4. Цусны хүчилтөрөгчийн хангамж 50%-иас буурах
 5. Хүчил-суурийн тэнцвэр $pH < 7.15$ болох
- /212./ Дараах эмгэгүүдийн алинд нь тогшилтын чимээ өөрчлөгдөх вэ?
1. Гялтанд хий, шингэн хуралдах
 2. Уушгинд авчилз үүсэх
 3. Кораны шинж
 4. Уушгины агааржилт ихсэх
 5. Философовын аяганы шинж
- /213./ Дууны доргио ямар тохиолдолд сулрах вэ ?
1. Уушгинд авчилз үүсэх
 2. Чээжний хөндийд шингэн хуралдах
 3. Чээжний гялтангийн хавдар
 4. Уушгины эд нягтран хатуурах
 5. Уушгинд хөндий үүсэх
- /214./ Амьсгалын эрхтний эмгэгийн үндсэн зовуурь
1. Хамар битүүрэх
 2. Хоолой сөөх, хоолой залгиур хөндүүрлэх
 3. Ханиалгах
 4. Чээжээр өвдөх
 5. Амьсгаадах
- /215./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед бага насны хүүхдэд илрэх зовуурь
1. Хөхөө хөхөх, хоол идэхээс татгалзах
 2. Халуурах
 3. Уйлагнуур, тайван бус болох
 4. Хоолой сөөнгөтөх
 5. Амьсгалахад саадтай болох
- /216./ Төвөнхийн үрэвслийг зонхилон үүсгэх вирусүүдийг нэрлэнэ үү?
1. Томуугийн А1, А2 хэвшинжүүд
 2. Иж томуугийн I, II хэвшинжүүд
 3. РС-вирус
 4. Аденовирус
 5. Ротавирус
- /217./ АЦХ-ын үед зонхилон хэрэглэдэг эмийн бэлдмэл
1. Цэр ховхлох
 2. Ханиалга намдаах
 3. Халуун бууруулах
 4. Өвчин намдаах
 5. Судсаар шингэн сэлбэх

- /218./ Бага насны хүүхдэд гуурсан хоолойн үрэвслийн үед илрэх зовуурь, эмнэлзүйн шинж
1. Хоолонд дургүйцэх
 2. Ханиах үедээ зовуурьтай уйлах
 3. Ялангуяа шөнө хүчтэй ханиалгах
 4. Өвчний 2 дахь 7 хоногоос ханиалга зөөлөрч цэр ховхрох
 5. Чээж хонхолзох
- /219./ АЦХ-тай хүүхдийн гэрийн эмчилгээ
1. Халуун бууруулах
 2. Хоолойн өвдөлт намдаах
 3. Ханиалга багасгах
 4. Амьсгал бачуурлыг намжаах
 5. Асаргааг сайжруулах
- /220./ Шимэгдүүлэх үйлчилгээтэй цэр ховхлох бэлдмэл
1. Пертуссин
 2. Иодот кали
 3. Иодот натри
 4. Бромгексин
 5. Амброксол
- /221./ Хүүхдийн хүзүүний хөшингийг үнэлэхдээ юуг анхаарах хэрэгтэй вэ?
1. Хүүхэд хүзүүгээ бөхийлгөхдөө зовуурьтай байгаа эсэх
 2. Эргэн тойрноо ажиглахдаа хүндрэлтэй байгаа эсэх
 3. Хүүхдийн толгойг цээж рүү нь болгоомжтой бөхийлгөхөд эсэргүүцэлтэй байгаа эсэх
 4. Хүзүүг нь бөхийлгөхөд уйлж байгаа эсэх
 5. Хөшингийг үнэлэхэд эргэлзээтэй байвал хүүхдийн анхаарлыг хүйс рүү хандуулах
- /222./ Амьсгалын дутагдлын III зэргийн үед илрэх эмнэлзүйн шинж
1. Хүүхдийн арьс саарал хөх туяатай болох
 2. Амьсгалын тоо хэвийн хэмжээнээс 50%-аар ихсэх
 3. Амьсгал өнгөц, хүйтэн болох
 4. Артерийн даралт буурах
 5. $pO_2=70$ мм. м.у.б түүнээс бага
- /223./ Бактерицид үйлчилгээтэй антибиотик
1. Пенициллин
 2. Цефалоспорин
 3. Полимиксин
 4. Ванкомицин
 5. Рифампицин
- /224./ АЦХ-тай хүүхдийг гэрээр эмчлэх заалт
1. Маш хүнд өвчин, хүнд хатгалгааны шинж тэмдэггүй
 2. Зөвхөн ханиадтай нярай хүүхэд
 3. Суурь өвчингүй буюу түүний хөнгөн зэрэгтэй
 4. Архаг өвчингүй
 5. Төвөнхийн бачууралтай
- /225./ Читамоны хэрэглэх эсрэг заалт
1. Бэлдмэлд хэт мэдрэг хүмүүс
 2. Жирэмсэн эхчүүд
 3. 2 хүртэлх настай хүүхдэд
 4. Элэгний хүнд өвчнүүд
 5. Халуунтай үед
- /226./ Дууны доргио доорх эмгэгүүдийн алинд нь ихсэх вэ ?
1. Чээжний хөндийд хий хуралдах
 2. Уушгины эд нягтран хатуурах
 3. Уушгинд авчилз үүсэх
 4. Уушгинд хөндий үүсэх
 5. Чээжний гялтангийн хавдрын үед
- /227./ Хүүхдийн уушгины хөгжлийг насны бүлгээр хэдэн үе хуваадаг вэ?
1. I үе 0-2 нас

2. II үе 2-5 нас
3. III үе 5-7 нас
4. IV үе 7-12 нас
5. V үе 12-15 нас

/228./ Асуумжийн аргаар тодруулах зүйл

1. Зовуурь
2. Өвчний түүх, өвчний явц, өвчлөхөд нөлөөлсөн хүчин зүйл
3. Амьдралын түүх
4. Харшилдаг эмийн бэлдмэлийг тодруулах
5. Биеийн ерөнхий байдлыг үнэлэх

/229./ Парацетамолын гаж нөлөө

1. Арьс загатнаж тууралт гарах
2. Нүүр хавагнах, нүүр хөхрөх
3. Цус багадах, цагаан эс цөөрөх
4. Цустай шээх
5. Зүрх, бөөр, элэгний үйл ажиллагаа хямрах

/230./ Хэдэн нас хүртэлх хүүхдэд байршлын тогшилт хийх боломжгүй вэ?

1. 1 нас
2. 3 нас
3. 5 нас
4. 7 нас
5. 9 нас

/231./ Цэр ховхорч буй үед ханиалга намдаах эм хэрэглэхэд гарах өөрчлөлт

1. Өвчний зовуурь багасах
2. Цэрний гадагшлалт саатах
3. Үрэвслийн шинж арилах
4. Гуурсны бөглөршилт гүнзгийрэх
5. Ханиалга багасаж, өвчний эдгэрэлт хурдсах

/232./ Гүйлсэн булчирхайн үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинж

1. Хүүхдийн бие тавгүйцэн хоолой сэргэж торох
2. Өндөр халуурч өвчин цочмог эхлэх
3. Шүлс залгих, юм идэж уухад өвдөлт нэмэгдэх
4. Заримдаа булчингууд болон үеэр өвдөх
5. Эрүүн доорх болон хүзүүний арын булчирхай томорч хөндүүрлэх

/233./ ХӨЦМ-ээр 11 сартай, 9 кг жинтэй хүүхдэд сальбутамол ямар тунгаар өгөх вэ?

1. 4 мг 2/1-ээр өдөрт 3 удаа 3 хоног
2. 4 мг 1/4-ээр өдөрт 3 удаа 5 хоног
3. 2 мг 1/2-ээр өдөрт 3 удаа 3 хоног
4. 2 мг 1/2-ээр өдөрт 3 удаа 5 хоног
5. 2 мг-аар өдөрт 3 удаа 5 хоног

/234./ Цэр ховхлох үйлдэлтэй эмийн бэлдмэлийн ангилал.

1. Салсархаг шүүрлийг шингэрүүлэх
2. Рефлексийн замаар үйлчилэх
3. Мукорегулятор
4. Шимэгдүүлэх үйлчилгээтэй
5. Уураг задлагч фермент

/235./ Тосгуур хоорондын таславчийн хоёрдогч цоорхой хаана байдаг вэ?

- A. Хоёр хавтаст хавхлагын дээр
- B. Зууван цонхны төв хэсэгт
- C. Таславчийн доод хэсэгт
- D. Анхдагч цоорхойн доор

/236./ Бага эргэлтэнд баяжилттай, хөхрөлттэй гажигт аль нь орох вэ?

- A. Гол судасны коарктац
- B. Ховдол хоорондын таславчийн цоорхой
- C. Эйзенменгер хам шинж
- D. Эбштейны өвчин

- Е. Фаллогийн дөрвөл
- /237./ Хэрэхээр ямар насны хүүхэд ихэвчлэн өвчлөх вэ?
- А. Хөхүүл
 - В. 2-3 нас
 - С. 4-6 нас
 - Д. 7-15 нас
 - Е. 15 аас дээш
- /238./ Аортын нарийслын онцлог
- А. Зүрхний оройн түлхэлт зүүн тийш шилжсэн
 - В. Зүрх бөмбөлөг хэлбэртэй
 - С. Бөмбөрийн дохиурын шинж илрэх
 - Д. Судасны дүүрэлт бага, удаан
 - Е. Агшилтын тод шуугиантай
- /239./ Зүрхний төрөлхийн гажгийн эмчилгээний зорилтонд орохгүй нь:
- А. Гэнэтийн тохиолдолд яаралтай зөв тусламж үзүүлэх
 - В. Янз бүрийн хүндрэл, хавсарсан эмгэгийг эмчлэх
 - С. Хүүхэд бүрт мэс засал хийлгэх
 - Д. Цаг тухайд нь зүрхний мэс засалч руу илгээх
- /240./ Хоёр хавтаст хавхлагын дутагдлын үед шуугиан аль цэгт сонсогдох вэ?
- А. I
 - В. II
 - С. III
 - Д. IV
 - Е. V
- /241./ Хоёр хавтаст хавхлагын дутмагшлын үед рентген зурагт дараах шинжүүдээс аль нь илрэхгүй вэ?
- А. Зүрхний бэлхүүс тодрох
 - В. Зүрхний зүүн тосгуур томрох
 - С. Зүрх-цээжний индекс ихсэх
 - Д. Зүрхний бэлхүүс тэгшрэх
 - Е. Зүүн ховдол томрох
- /242./ Эбштейны аномалийн үед ЭКГ-д илрэхгүй шинж
- А. Баруун тосгуурын томрол
 - В. Барууны хазайлт
 - С. Эмгэг Q шүд
 - Д. АВ дамжуулалт уртсах
- /243./ Цусны эргэлтийн алдагдлын II а үед ямар шинж тэмдэг илрэхгүй вэ?
- А. Зүрхний цохилт түргэсэх
 - В. Амьсгаадах
 - С. Хөхрөх
 - Д. Элэг томрох
 - Е. Хэвлийд шингэн хуралдах
- /244./ Аль нь хүүхдэд хамгийн элбэг тохиолддог вэ?
- А. Параксизмийн тахикарди
 - В. Экстрасистол
 - С. АВ бүтэн хориг
 - Д. Амьсгалын гаралтай зүрхний хэм алдагдал
 - Е. Синусын брадикарди
- /245./ Фаллогийн дөрвөлд аль нь орохгүй вэ?
- А. Уушгины артерийн нарийсалт
 - В. Аортын нарийсалт
 - С. Ховдол хоорондын таславчийн цоорхой
 - Д. Аорт баруун тийш хэлтийх
 - Е. Баруун ховдлын хана зузаарах
- /246./ Зүрхний дутмагшлын IIб үед илрэхгүй шинжийг заа.
- А. Эрхтэн тогтолцоонд эргэлтгүй тэжээлийн хямрал гарна

- В. Захын хөхрөлт
 - С. Уушги хавагнах
 - D. Хүчил-суурийн тэнцвэр алдагдах
- /247./ Зүрхний дутагдлын эмгэг жамд орохгүйг заа.
- A. Агшилтын эзлэхүүн багасах
 - B. Зүрхний булчинд К-ийн хуваарилалт алдагдах
 - С. Минутын эзлэхүүн ихсэх
 - D. Хүчилтөрөгчгүйдэл
 - E. Венийн даралт ихсэх
- /248./ Цочмог явцтай анхдагч хэрэхийн үед зүрх гэмтэх нь хэр элбэг тохиолдох вэ?
- A. 10-15%
 - B. 20-25%
 - С. 40-45%
 - D. 60-55%
 - E. 80-85%
- /249./ Артерийн битүүрээгүй цоргын үед сонсогдох онцлог шуугиан
- A. Систолын шуугиан
 - B. Диастолын шуугиан
 - С. Сулралын богино шуугиан
 - D. Трехем-Стиллийн шуугиан
 - E. Машины шуугиан
- /250./ Зүрхний дутагдал ихэвчлэн зүрхний аль хэсгийн эмгэгтэй холбоотой үүсэх вэ?
- A. Зүрхний дотор бүрхэвч
 - B. Зүрхний булчин
 - С. Үнхэлцэг хальс
 - D. Сэрэл дамжуулах тогтолцоо
 - E. Титэм судас
- /251./ Миокардитын оношилгооны I шатны дунд оноот шинж аль нь вэ?
- A. Зүрхээр өвдөх
 - B. ЭКГ-д зүрхний булчин томорсон
 - С. Бодит үзлэгт зүрх томорсон
 - D. Эктоник хэмнэл
 - E. АВ хориг
- /252./ Ховдол хоорондын таславчийн цоорхойн үед илрэхгүй шинжүүд
- A. Амьсгалын замын цочмог өвчнөөр байнга өвдөх
 - B. Амьсгаадах
 - С. Диастолын даралт хэвийн байна
 - D. Нойтон хэржигнүүр сонсогдоно
 - E. Систолын даралт ихэснэ
- /253./ ЮРА өвчний рентген шинж
- A. Үений завсар холдох
 - B. Булчин хатангирших
 - С. Үе орчим яс сийрэгжсэн
 - D. Үе үрэвссэн
 - E. Үений хөшөнги
- /254./ Гол судасны хавхлагын дутмагшлын үед дараах шинжүүдээс аль нь илрэхгүй вэ?
- A. Агшилтын даралт ихсэх
 - B. Сулралын даралт буурах
 - С. Хялгасан судасны лугшилт илрэх
 - D. Судасны лугшилт хүчтэй, хурдан болох
 - E. Гүрээний судасны лугшилт тодрох
- /255./ Тэлэгдлийн кардиомиопати
- A. Зүүн ховдлын хөндий эрс тэлэгдэнэ
 - B. Зүүн ховдол, ховдол хоорондын таславчийн булчин хэт зузаарах

- С. Ховдлын ханын суналт, тэлэлт алдагдах
- /256./ Бага насны хүүхдэд тохиолдох зүрхний булчингийн үрэвсэл голчлон ямар шалтгаантай байх вэ?
- А. Нян
 - В. Вирус
 - С. Харшил
 - Д. Хордлого
 - Е. Холбогч эдийн түгээмэл үрэвсэл
- /257./ Төрөлхийн гажгуудын дотроос хамгийн элбэг тохиолддог нь аль нь вэ?
- А. Тосгуур хоорондын таславчийн цоорхой
 - В. Ховдол хоорондын таславчийн цоорхой
 - С. Артерийн битүүрээгүй цорго
 - Д. Фаллогийн өвчин
 - Е. Нэгдсэн ховдол тосгуур
- /258./ Тосгуур хоорондын таславчийн цоорхойтой хүүхдийн эмнэлзүй хэдэн наснаас илэрч эхлэх вэ?
- А. 1 нас
 - В. 5 нас
 - С. 2 нас
 - Д. Төрөнгүүтээ
 - Е. 10 нас
- /259./ Хүүхдийн үнхэлцгийн үрэвслийн голлох шалтгаан
- А. Холбох эдийн түгээмэл өвчин
 - В. Вирус
 - С. Бөөрний дутагдал
 - Д. Стафилококк
 - Е. Сүрьеэ
- /260./ 3-7 настай хүүхдэд ЮРА илрэх онцлог
- А. Рентгенд яс мөгөөрсний гэмтэл илэрнэ
 - В. Серологит өөрчлөлт илэрнэ
 - С. Үений өөрчлөлт 2 талдаа ижил бус
 - Д. Булчин хатангиршина
 - Е. Үений өөрчлөлт хөнгөн
- /261./ Бага эргэлтэнд баяжилттай төрөлхийн гажигт аль нь орохгүй вэ?
- А. Артерийн битүүрээгүй цорго
 - В. Тосгуур хоорондын таславчийн цоорхой
 - С. Ховдол хоорондын таславчийн цоорхой
 - Д. Эбштейны аномали
- /262./ Хэрэхийн шалтгаантай олдмол гажгаас хамгийн элбэг тохиолдохыг нь сонго.
- А. Гол судасны хавхлагын дутмагшил
 - В. Гол судасны хавхлагын нүхний нарийсал
 - С. Хоёр хавтаст хавхлагын дутмагшил
 - Д. Хоёр хавтаст хавхлагын нүхний нарийсал
 - Е. Гурван хавтаст хавхлагын дутмагшил
- /263./ Зүрхний төрөлхийн гажгийг эмгэг жам, эмнэлзүйгээр нь хэдэн үе шат болгодог вэ?
- А. 6
 - В. 5
 - С. 4
 - Д. 3
 - Е. 2
- /264./ Миокардитын оношлогооны I шатны өндөр оноот шинж аль нь вэ?
- А. Төвөргөөнт хэм
 - В. АВ хориг
 - С. I авиа бүдгэрэх
 - Д. ЭКГ-д зүрхний булчин томорсон
 - Е. Зүрхний дутагдалтай байх

- /265./ ЮРА өвчний хүүхдэд тохиолдох давтамж
- A. 10000:54
 - B. 1000:0.5
 - C. 1000:0.05
 - D. 100001
 - E. 5000:3
- /266./ Гол судасны хавхлагын нүхний нарийслын үед ямар шуугиан хаана сонсогдох вэ?
- A. II цэгт сулралын шуугиан
 - B. II цэгт агшилтын шуугиан
 - C. III цэгт сулралын шуугиан
 - D. III цэгт агшилтын шуугиан
 - E. I цэгт сулралын шуугиан
- /267./ Зүрхний гликозидын барих тун ямар байх вэ?
- A. Хангах тунгийн хагастай тэнцүү
 - B. Хүүхдийн биеийн жингээс хамаарна
 - C. Тухайн бэлдмэлийн биеэс зайлуулагдах коэффициенттэй тэнцүү
 - D. Зүрхний дутлын зэргээс хамаарна
 - E. Ямар аргаар хэрэглэснээс хамаарна
- /268./ Аортын нарийслын үед эгзэгтэй байдал хэдийд үүсэх вэ?
- A. Ахлах насны хүүхдэд
 - B. Нарийсалт бага үед
 - C. Судасны голч 0.5 см-ээс бага, хүүхэд 6 сар хүрээгүй үед
 - D. Судасны голч 0.5 см-с их, хүүхэд 6 сар хүрээгүй үед
 - E. Судасны голч 0.5 см-с бага, хүүхэд 6 сараас дээш настай үед
- /269./ Хэрлэгийн үндсэн шалгуур аль нь вэ?
- A. Үеэр хэрж өвдөх, халуурах
 - B. Хамраас цус гарах
 - C. Ядрах
 - D. С-урвалж уураг ихсэх
 - E. Олон үений үрэвсэл
- /270./ Хэрэх өвчний үед ямар хавхлага илүүтэй гэмтэх вэ?
- A. Гол судасны хавхлага
 - B. Хоёр хавтаст хавхлага
 - C. Гурван хавтаст хавхлага
 - D. Уушгины артерийн хавхлага
 - E. Аль аль нь
- /271./ Цусны эргэлтийн алдагдлын I үед ямар шинж тэмдэг илрэх вэ?
- A. Ачааллын үед амьсгаадна
 - B. Тайван үед зүрх дэлсэж, амьсгаадна
 - C. Хүүхэд хөхөө амарч хөхнө
 - D. Элэг томорно
 - E. Хавагнана
- /272./ Эйзенменгерийн хамшинжийн гол шинж
- A. Хөхрөх
 - B. Уушгины артерийн даралт ихсэх
 - C. Цусны урсгал баруунаас зүүн рүү чиглэх
 - D. Цусны урсгал зүүнээс баруун руу чиглэх
 - E. Уушгины артер дээр II авианы өргөлт тодрох
- /273./ Үнхэлцгийн хөндийд шингэн эсвэл фибрин хуримтлагдах үед илрэхгүй шинжийг заа.
- A. Зүрх орчим өвдөх
 - B. Үнхэлцгийн шүргэлцэх чимээ
 - C. Элэг дэлүү томрох
 - D. Зүрхний сүүдэр томрох
- /274./ Аль нь зөв бэ?
- A. Хэвийн үед гол судасны голч зүүн тосгуурын хэмжээтэй тэнцүү байдаг.
 - B. Хэвийн үед зүүн тосгуурын хэмжээ голсудасны голчоос их байдаг.

- С. Хэвийн үед зүүн тосгуурын хэмжээ гол судасны голчоос бага байдаг.
- /275./ Ямар тохиолдолд далд явцтай хэрэх гэж үзэх вэ?
- А. Хүүхэд өндөр халуурсан
 - В. Эмнэлзүй ба шинжилгээнд өөрчлөлтгүй атлаа олдмол гажиг үүссэн
 - С. Эмнэлзүйн илрэлгүй атлаа шинжилгээнд УЭТХ ихэссэн
 - Д. Бодит үзлэг, шинжилгээнд өөрчлөлтгүй ч зүрхээр хатгаж өвдөнө гэсэн зовиурьтай
 - Е. Үеэр өвдөж, хавдсан
- /276./ Аль нь миокардитын оношлогооны I шатны бага оноот шинжид орохгүй вэ?
- А. Зүрхний эсрэгтөрөгч ба зүрхний эсрэг бие цусанд илрэх
 - В. АВ хориг
 - С. Зүрхний оройд агшилтын шуугиан
 - Д. Эктоник хэмнэл
 - Е. I авиа бүдгэрэх
- /277./ Хэрлэгийн анхдагч сэргийлэлт юу вэ?
- А. Стрептококкийн дахилтаас сэргийлэх
 - В. Стрептококкын халдвараас сэргийлэх
 - С. Зүрх гэмтэхээс сэргийлэх
 - Д. Аспирин уух
- /278./ Чонон яр өвчний шинжид орохгүйг заа.
- А. Үений үрэвсэл
 - В. Нарны гэрэлд мэдрэг
 - С. Үений хөшингө
 - Д. Эрвээхий хэлбэрийн тууралт
 - Е. Антинуклеар эсрэгбие
- /279./ Хүүхэд албадмал байрлалд ордог эмгэг
- А. Фаллогийн дөрвөл
 - В. Эйзенменгер хам шинж
 - С. Аортын коарктаци
 - Д. Гурван хавтаст хавхлагын нарийсалт
- /280./ Хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийн шалтгаанд аль нь орохгүй вэ?
- А. Жирэмсний сүүлийн 3 сард хүнд хордлоготой байх
 - В. Удамшил
 - С. Ионжуулах цацраг
 - Д. Жирэмсний эхний 3 сард хүнд хордлоготой байх
 - Е. Хорт зуршил
- /281./ Бага насны хүүхдэд миокардит үүсэх зонхилох шалтгаан
- А. Энтеровирус
 - В. Стрептококк
 - С. Стафилококк
 - Д. Аденовирус
 - Е. Эмийн бодис
- /282./ Зүрхний дутмагшлын I зэргийн үед илрэхгүй шинжийг заа.
- А. Тайван үед зүрхний цохилт олшрох
 - В. Ачааллын үед амьсгаадах
 - С. Тасалдаж хөхөх
 - Д. Хамар-уруулын орчим хөхрөх
 - Е. Бодисын солилцоо хямрах
- /283./ Хоёр хавтаст хавхлагын дутмагшлын үед шуугиан дараах цэгт сонсогдоно.
- А. Зүрхний оройд
 - В. II цэгт
 - С. III цэгт
 - Д. IV цэгт
 - Е. V цэгт
- /284./ Хөхүүл насны хүүхдэд дигоксины хангах тун ямар байх вэ?
- А. 0.005 мг/кг
 - В. 0.075 мг/кг

C. 0.01 мг/кг

D. 0.1 мг/кг

E. 1 мг/кг

/285./ Тосгуур хоорондын таславчийн цоорхойн үед сулралын богино шуугиан хаана сонсогдох вэ?

A. I цэгт

B. II цэгт

C. III цэгт

D. IV цэгт

E. V цэгт

/286./ Ховдол хоорондын таславчийн цоорхой гажгийн үед бага эргэлтэнд цус хомсдох учраас хүүхэд ханиад хүрэмтгий байна.

/287./ 46. Ховдол хоорондын таславчийн цоорхойн төгсгөлийн шатанд бага эргэлтийн даралт эрс ихсэх учраас цус юүлэлтийн чиглэл өөрчлөгдөн хөхрөлт илэрнэ.

/288./ Томуугийн вирус нь кардиомиоцит эсийг шууд гэмтээх учраас зүрхний булчинг үрэвсүүлнэ.

/289./ Хэрэх өвчний гол үүсгэгч нь цус задлагч стрептококк учраас эмгэгтөрөгч шууд зүрхийг гэмтээнэ.

/290./ Зүрхний дутагдлын үед зүрхний булчингийн агшилт суларснаас биеэр цус эргэх үйл ажиллагаа хямарна.

/291./ Амьдралын эхний хоногт шарлалт үүсгэх шалтгааныг заана уу.

1. Нярайн цус задрах өвчин

2. Үжил

3. Ургийн халдвар

4. Цус харвалт

5. Цусны эс олширох

/292./ Бүтэлттэй төрсөн нярайд авах зөв арга хэмжээг ол

1. Түргэн хугацаанд хуурайшуулан, зөв байрлуулна

2. Амьсгалын замыг чөлөөлнө

3. Хиймэл амьсгал хийнэ

4. Төрмөгц алгадаж, сэгсэрч цочрооно

5. Зүрхэнд массаж хийж ам хамраас салиаг соруулна

/293./ 26. Улаануудын төрөлхийн халдварын үед тохиолдох гаж хөгжлийг олно уу

1. Зүрхний гажиг

2. Нүдний гажиг

3. Дүлий

4. Ивэрхий

5. Мөчдийн гажиг

/294./ Дасан зохицлын үед бөөрний талаас гарах өөрчлөлтийг заана уу.

1. Шээсээр уураг ялгарах

2. Шээс ховордох

3. Шээсний хүчлийн инфаркт

4. Цустай шээх

5. Шээхэд өвдөх

/295./ Төрөлхийн токсоплазмозыг ямар үед сэжиглэх вэ?

1. Шарлалт удаан үргэлжлэх

2. Элэг, дэлүү томрох

3. Таталт, гидроцефали

4. Тархины кальцификат, тархины даралт их

5. Нүдний эмгэгтэй хавсарсан оюуны хомсдол

/296./ Нярайг хэдийд амлуулах вэ?

1. Хөхөнд сүү орсон үед
2. 24 цаг болоод
3. Ангир уургаа саасны дараа 3 цаг тутамд
4. 30 минутаас 1 цагийн дотор
5. Төрсний дараа 20 минутын дотор амлуулна

/297./ Ямар тохиолдолд нярайд антибиотик эмчилгээг эхлэх вэ?

1. Нярайн нян судлалын шинжилгээ эерэг байвал
2. Нярайд үжлийн шүүлтүүрээс 2 үзүүлэлт эерэг байвал
3. Нярайд халдварын эмнэл зүй тодорхой байвал
4. Нярай бүтэлттэй төрсөн бол
5. Нярай дутуу төрсөн бол

/298./ Хөх чинэсэн үед хүүхдээ хөхүүлэхийн өмнө окситоцины ялгаралтыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?

1. Бүлээн шүршүүрт орох
2. Хөхөндөө иллэг хийх
3. Хөхний толгойг имрэх
4. Хөхөндөө бүлээн жин тавих
5. Хүзүү нуруунд иллэг хийх

/299./ Төрөх өрөөнд нярай хөхөө амлаж чадахгүй байна. Та ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Хэсэг хугацааны дараа хөхөж чаддаг болно гэж тайвшруулна
2. Сайн тэврээд хөхүүлэхийг оролдохыг зөвлөнө
3. Заавал хөхөө амлах шаардлагагүй болохыг хэлнэ
4. Эхэд тусална
5. Хөхөнд сүү ортол хүлээхийг зөвлөнө

/300./ Төрөлхийн тэмбүүтэй хүүхдэд илрэх гол шинж тэмдэг юу вэ?

1. Ургийн өсөлтийн саатал
2. Хамар битүү
3. Гар, хөлийн улаар цэврүүтэй
4. Ургийн ус бохир ногоон
5. Бүтэлттэй төрдөг

/301./ Амьсгалын дистресс хамшинжийн үед илрэх эмнэлзүйн нийтлэг шинжүүд:

1. Амьсгал олшрох
2. Амьсгал гаргахдаа яраглах
3. Амьсгалд туслах булчингууд оролцох
4. Хөхрөх
5. Чээжний 2 тал амьсгалд жигд бус оролцох

/302./ Нярайн булчингийн хүчдэл ихсэлт ямар эмгэгүүдийн үед илрэх вэ?

1. Тархины даралт ихсэх
2. Мэнэн
3. Цөмөн шарлалт
4. Дутуу төрөлт
5. Үжил

/303./ Дөнгөж төрсөн нярай хүүхдэд анхны үзлэгийг хэдийд хийх вэ?

1. 1 минутын дараа апгарын үнэлгээ хийнэ
2. 5 минутын дараа хийнэ
3. Төрсний дараах 1 цагт хийнэ
4. Нярайг хуурайшуулсны дараа хийнэ
5. Үзлэг хийх боломжтой үед хийнэ

/304./ Хомхойн халдварын үед ямар ямар хожуу үлдэц илрэх вэ?

1. Сохрох
2. Дүлийрэх
3. Тархины эмгэгшил
4. Сэтгэц-хөдөлгөөний хоцрогдол
5. Уушгины үрэвсэл

/305./ Хүүхдийн биеийн жингийн индекс (БЖИ)-тэй холбоотой зөв хариултыг сонго

1. БЖИ 18.5-24.9 кг/м² байх нь хэвийн үзүүлэлт
 2. БЖИ = биеийн жин (кг): биеийн өндөр² (м²)
 3. БЖИ 30 ба түүнээс их бол таргалалттай гэж үзнэ
 4. БЖИ-ийн 85-95-р муруйн хооронд байгаа үзүүлэлтийг илүүдэл жинтэй гэнэ
 5. БЖИ-ийн 3-10-р муруйн хооронд байгаа хэмжээг тураал гэж үнэлнэ
- /306./ Нярайн халдвар үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:
1. Ураг орчмын шингэн эрт гарах
 2. Эхийн бэлгийн замын халдвар
 3. Бага жинтэй төрөх
 4. Төрөхдөө бүтэх
 5. Гараа муу угаах
- /307./ Нярай хүүхдийн биеийн хэвийн халуун хэдэн хэм байдаг вэ?
1. 37-38.0С
 2. 36-38.50С
 3. 35-36 0С
 4. 36.5-37.40С
 5. 35-360С
- /308./ Нярайн чээжний рентген зурагт чээжний хөндийд агаар байгааг хэрхэн үнэлэх вэ?
1. Амьсгалын замын бөглөрөл
 2. Уушгины дутуу хөгжил
 3. Уушгинд цус харвалт
 4. Пневмоторакс
 5. Уушгины үрэвсэл
- /309./ Нярай хүүхдийг хөхөөр хооллохтой холбоотой буруу зөвлөгөөг олно уу.
1. Ангир уураг нь хүүхдэд хэрэгцээтэй шимт бодисыг агуулсан байдаг
 2. Шөнө хөхүүлэх нь сүүний гарцыг бууруулна
 3. Хөхөө ойр ойрхон хүүхдээ хүссэн үед нь хөхүүлэх нь чухал
 4. Ангир уураг маш бага хэмжээтэй тул чихэртэй усаар нэмж угжина
 5. Шөнө хөхүүлэх нь сүүний гарцыг сайжруулна
- /310./ Нярайн булчингийн сулрал ямар эмгэгүүдийн үед илрэх вэ?
1. Бүтэлт
 2. Мэдрэл-булчингийн төрөлхийн өвчин
 3. Тархи-нугасны гэмтэл
 4. Дауны хамшинж
 5. Дутуу нярай
- /311./ Төрөх өрөөнд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг чандлан сахина. Үүнд:
1. Цэвэр гар
 2. Цэвэр талбай
 3. Цэвэр даавуу, өлгий
 4. Хүй таслах, боох хэрэгсэл ариун байх
 5. Эх, нярайд хэрэглэх багаж, хэрэгсэл ариун
- /312./ Амьсгалын дистресс хамшинжийн хөнгөн үед хүчилтөрөгч эмчилгээг хэрхэн хийх вэ?
1. Аппаратаар өгнө
 2. Майхан ба маскаар өгнө
 3. Чөлөөт урсгалаар өндөр даралтаар өгнө
 4. 2-6 хоног хүчилтөрөгч өгнө
 5. 2 долоо хоногоос доошгүй хугацаагаар өгнө
- /313./ Биеийн дулаан бууралтын эмнэлзүйн шинжүүдийг заана уу.
1. Амьсгал түргэсч, зүрхний цохилт хурдсана
 2. Хөдөлгөөний идэвх суларч, хөхөндөө муудна
 3. Бие нь хөрч, хөдөлгөөн ихсэнэ
 4. Амьсгал ба зүрхний цохилт цөөрнө
 5. Арьсны өнгө ягаарна
- /314./ Нярайн төрөлхийн хомхойн эмнэлзүйн илрэлийг заана уу?
1. Арьс, салст, нүдний хэлбэр
 2. Үжилт хэлбэр

3. Мэнэн, энцефалит
4. Элэгний үрэвсэл
5. Уушгины үрэвсэл

/315./ Нярайн цус задрах өвчнийг сэжиглэж байгаа үед ямар шинжилгээнүүдийг хийхээр төлөвлөх вэ?

1. Эх, хүүхдийн цусны бүлэг, резус хүчин зүйлийг тодорхойлох
2. Хүүхдийн захын цусанд ретикулоцит тодорхойлох
3. Хүүхдийн цусны билирубиныг тодорхойлох
4. Кумбсын сорил
5. Хүүхдийн цусны уураг тодорхойлох

/316./ Ямар нярай жингээ илүү алддаг вэ?

1. Дутуу нярай
2. Даарсан
3. Чийглэг бага орчинд байгаа
4. Эрт амлуулсан
5. Эмэгтэй хүүхэд

/317./ Төрөх өрөөнд түргэн төрөлтөөр төрсөн нярай амьдралын эхний минутад амьсгал тогтворжоогүй, зүрхний цохилт 1 минутанд 140 удаа, хөл ба гарын үзүүр хөхөрсөн, булчингийн хүчдэл суларсан, цочролд сул хариулна. Бүтэлтийг ангилж, Апгарын оноог тогтооно уу.

1. Хүнд бүтэлт
2. Хүндэвтэр бүтэлт
3. Апгарын оноо 5
4. Апгарын оноо 6
5. Апгарын оноо 7

/318./ Ямар тохиолдолд цитомегаловирусийн төрөлхийн халдвартай гэж үзэх вэ?

1. Эх, хүүхдийн цусанд ЦМВ-ийн эсрэг IgG илэрсэн
2. Цитомегаловирусийн геном илэрсэн
3. Давтан шинжилгээгээр хүүхдийн цусны ЦМВ-ийн эсрэг IgG эхийнхээс 1.5-2 дахин буурсан
4. Хүүхдийн цусны ЦМВ-ийн эсрэг IgG эхийнхээс 4 дахин өндөр
5. Хүүхдийн цусны ЦМВ-ийн эсрэг IgG эхийнхээс 4 дахин бага

/319./ Хөх чинэсэн үед хүүхдээ хөхүүлэхийн өмнө окситоцины ялгаралтыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?

1. Бүлээн шүршүүрт орох
2. Хөхөндөө иллэг хийх
3. Хөхний толгойг имрэх
4. Хөхөндөө бүлээн жин тавих
5. Хүзүү нуруунд иллэг хийх

/320./ Нярайд хийгддэг урдчилан сэргийлэх арга хэмжээг заана уу

1. Нүдний үрэвслээс сэргийлэх
2. Цусархаг хамшинжээс сэргийлж К-аминдэм тарих
3. БЦЖ, халдварт саа, В-гепатитын эсрэг вакцин тарих
4. Халдвараас сэргийлж тусгаарлах
5. Антибиотик уулгах

/321./ Хүүхдийн таргалалтын шалтгаан юу байж болох вэ?

1. Хэтрүүлэн хооллох
2. Хөдөлгөөний хомсдол
3. Удамшил
4. Зарим өвчний үед хөдөлгөөн хорих
5. Моноамины солилцооны төрөлхийн онцлог

/322./ Нярай хүүхдэд допаминыг их тунгаар хэрэглэхэд гарах гаж нөлөөг нэрлэнэ үү?

1. Зүрхний цохилт олшрох
2. Зүрхний хэм алдагдах
3. Уушгины даралт ихсэх
4. Зүрхний цохилт удаашрах

5. Зах хязгаарын судас өргөсөх
- /323./ Гипотермийн эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу.
1. Амьсгал түргэсч, зүрхний цохилт хурдасна
 2. Хөдөлгөөний идэвх суларч, хөхөндөө муудна
 3. Бие нь хөрч, хөдөлгөөн ихсэнэ
 4. Амьсгал, зүрхний цохилтын тоо цөөрч, амин чухал эрхтний үйл ажиллагаа дарангуйлагдана
 5. Арьсны өнгө ягаарна
- /324./ Физиологийн шарлалт эмгэг шарлалтаас ялгагдах шинж нь:
1. Төрмөгц үүсээд удаан үргэлжилдэг
 2. Төрсний дараах 2-3 хоногт үүсдэг
 3. Шарлалт арилсны дараа дахин үүсч болдог
 4. 10-аас илүүгүй хоноод арилдаг, биенд ямар нэгэн зовуурьгүй
 5. Билирубины хэмжээ 12 мг%-аас их болно
- /325./ Ураг, нярайн халдварт өртөх эрсдэлт хүчин зүйлд аль нь хамаарах вэ?
1. Ураг орчмын шингэн үнэртэй байх, ус ихтэй байх
 2. Дутуу төрөлт
 3. Эх барихын ажилбарууд
 4. Эхийн эрүүл ахуй сайн
 5. Бүтэлттэй төрж, сэхээн амьдруулах арга хэмжээ авагдсан байх
- /326./ Шилжилтийн амьсгаадалт үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлийг заана уу
1. Кесар хагалгаа
 2. Өгзөг түрүүлэлт
 3. Эр хүйс
 4. Уургийн дутал
 5. Гүйцэд төрөлт
- /327./ Уушгины үрэвсэл үүсэхэд нөлөөлөх урьдал хүчин зүйлийг заана уу.
1. Ураг орчмын шингэн урьтаж гараад, усгүй үе удаан үргэлжлэх
 2. Төрөх үед үтрээний үзлэгийг олон дахин хийх
 3. Эх нь ямар нэг халдвартай байх /амьсгалын, шээс бэлгийн гэх мэт/
 4. Дутуу төрөлт
 5. Ургийн хөгжлийн саатал
- /328./ Нярайн дулаан алдалтын шалтгаанд аль нь орох вэ?
1. Биеийн нэг кг жинд ноогдох талбай их
 2. Амьсгалын минутын эзлэхүүн насанд хүрэгчдийнхээс их
 3. Бор өөх багатай
 4. Хөхний сүүнээс өөр хоол иддэггүй учраас
 5. Арьсан доорх өөхөн эдийн хөгжил сайн
- /329./ Зунгагаар хахсан бүтэлттэй төрсөн нярайд цаашид гарах хүндрэлийг заана уу.
1. Авчилз үүснэ
 2. Уушгины үрэвсэл
 3. Гуурсан хоолой бөглөрөх
 4. Уушги хэт тэлэгдэх
 5. 4Плеврит
- /330./ Нярайг хэдийд амлуулах вэ?
1. Хөхөнд сүү орсон үед
 2. 24 цаг болоод
 3. Ангир уургаа саасны дараа 3 цаг тутамд
 4. 30 минутаас 1 цагийн дотор
 5. Төрсний дараа 20 минутын дотор амлуулна
- /331./ Үжлийн шалгуурт орохгүй шинж нь аль вэ?
1. Цагаан эсийн тоо $<5 \times 10^9 / \text{л}$, эсвэл $>20 \times 10^9 / \text{л}$
 2. С-урвалж уураг эерэг
 3. СОЭ $>15 \text{ мм/ц}$
 4. Ямар нэгэн нянгийн өсгөвөрт эмгэг төрөгч ургах
 5. Залуу эс ба нийт эсийн харьцаа >0.4

/332./ Цусны чихэр багадалт хэдийд зонхилон тохиолдох вэ?

1. Төрмөгц
2. Амьдралын эхний 24 цагт
3. Амьдралын эхний 48 цагт
4. Амьдралын эхний 3 хоногт
5. Амьдралын эхний 7 хоногт

/333./ Амьсгалын дистресс хамшинжийн хөнгөн үед хүчилтөрөгч эмчилгээг хэрхэн хийх вэ?

1. Аппаратаар өгнө
2. Майхан ба маскаар өгнө
3. Чөлөөт урсгалаар өндөр даралтаар өгнө
4. 2-6 хоног хүчилтөрөгч өгнө
5. 2 долоо хоногоос доошгүй хугацаагаар өгнө

/334./ Төрөлхийн тэмбүүтэй хүүхдэд ямар антибиотик сонгох вэ?

1. Эритромицин
2. Амоксициллин
3. Хлорамфеникол
4. Пенициллин G
5. Ципрофлоксацин

/335./ Трансфераза ферментийн идэвхжлийг бууруулах хүчин зүйлийг заана уу

1. Хүчилтөрөгчийн дутмагшил
2. Халдварын гаралтай өвчин
3. Нярайн дулаан алдалт
4. Бамбай булчирхайн дутал
5. Халууралт

/336./ Бүтэлттэй төрсөн нярайд цочрооход дараах аргын аль нь тохиромжгүй вэ?

1. Түргэн хуурайшуулангаа цочроох
2. Өгзөгийг алгадах
3. Хөлийн улыг алгадах
4. Халуун, хүйтэн усаар ээлжлэн шүрших
5. Нурууг илэх

/337./ Цитомегаловирусийн төрөлхийн халдварын үед илрэх эмнэлзүйн гол шинжүүд:

1. Цусархаг тууралт
2. Элэг, дэлүү томрох
3. Шарлалт
4. Гидроцефали
5. Том жинтэй төрөх

/338./ Нярайн дулааны хэлхээнд орохгүй зүйлийг заана уу?

1. Төрөх өрөө нэвт салхигүй дулаан байх
2. Нярайн өлгий, даавуу, бусад хэрэглэгдэх зүйлс дулаан байх
3. Төрөх өрөөний дулаан 25°C байх
4. Эхээс тусгаарлан, өлгийдөж тавих
5. Малгай өмсгөх

/339./ Ямар үед хүүхэд гэнэт часхийн, хөлөө тийчилж, уйлах вэ?

1. Гэдэс дүүрэх
2. Чих өвдөх
3. Ивэрхий хавчигдах
4. Гэдэс түгжрэх
5. Мухар олгойн үрэвсэл

/340./ Хүйн үрэвслийн шинж тэмдэг юу вэ?

1. Хүйнээс ялимгүй хэмжээтэй, өнгөгүй шүүс гарна
2. Хүйнээс идээ гарна
3. Хүйн судас тэмтрэгдэхгүй
4. Хүй улайж, хавдсан
5. Хүй цөглөөгүй

/341./ Нярайн эмчилгээнд фуросемидийн үзүүлэх үйлчилгээ юу вэ?

1. Бөөрний ачаалал ихэсгэх

2. Шээс хөөх
 3. Даралт ихэсгэх
 4. Судас өргөсгөх
 5. Зүрхний дутагдлыг нэмэгдүүлэх
- /342./ Нярайн дулаан алдалтын (гипотермийн) шалтгаанд аль нь орохгүй вэ?
1. Биеийн нэг кг/жинд ногдох гадаргуугийн талбай
 2. Арьсан доорх өөхөн эдийн хөгжил сайн
 3. Амьсгалын минутын эзлэхүүн насанд хүрэгсдийнхээс их
 4. Хөхний сүүнээс өөр хоол иддэггүй учраас
 5. Бор өөх багатай
- /343./ Нярайн шарлалт яагаад үүсдэг вэ?
1. Эритроцитын амьдрах хугацаа богино
 2. Элэгний коньюгацын үйл ажиллагаа хангалтгүй
 3. Гэдэсний ханаар билирубины зарим нь эргэн шимэгддэг
 4. Стеркобилин их үүсдэг
 5. Дээрх бүгд
- /344./ Бага жинтэй нярайг дулаан байлгах аргуудыг нэрлэнэ үү.
1. Дулаан өрөө тасалгаа
 2. Дээрээсээ халдаг ширээ
 3. Имж эх арга
 4. Агаар халаагчтай инкубатор
 5. Малгай өмсгөх
- /345./ Түгээмэл тохиолддог амьсгалын дистресс хамшинжийг нэрлэнэ үү
1. Гиалин бүрхүүлт өвчин
 2. Шилжилтийн үеийн амьсгаадалт
 3. Уушгины үрэвсэл
 4. Зунгагт хахах хамшинж
 5. Пневмоторакс
- /346./ Сурфактант ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
1. Амьсгал гаргалтанд уушги шалчийхаас сэргийлнэ.
 2. Цулцангийн хучуур эсийг гэмтэхээс хамгаална
 3. Уушгины бичил эргэлтийн зохицуулгад оролцож уушгины хаван үүсэхээс сэргийлнэ
 4. Уушгины агааржилтыг бууруулж, авчилз үүсгэнэ
 5. Гиалин бүрхүүлт өвчин үүсэхээс сэргийлнэ.
- /347./ Анхдагч апноэгийн үед илрэх шинжийг сонгоно уу?
1. Зүрхний цохилтын тоо цөөрөх
 2. Цочрооход хариу үзүүлэх
 3. Арьс цонхийж цайх
 4. Гасп хэлбэрээр амьсгалахыг оролдох
 5. Цусны даралт унах
- /348./ Доорх тохиолдлоос аль нь эмгэг шарлалтад орох вэ?
1. Эхний 24 цагт шарлалт илэрвэл
 2. Шууд бус билирубины хэмжээ 1 хоногт 5 мг%-иар нэмэгдэж байвал
 3. Шууд билирубин >2 мг%
 4. Нийт билирубин >15 мг%
 5. Амьдралын эхний хоногт хүйн цусны билирубин 60 мкмоль/л хүртэл
- /349./ Аль нь нярайн халдвар вэ?
1. Мэнэн
 2. Амьсгалын дээд замын үрэвсэл
 3. Гэдэсний үхжилт үрэвсэл
 4. Нүдний үрэвсэл
 5. Амны мөөгөнцөр
- /350./ Ургийн халдвар хэдийд үүсдэг вэ?
1. Төрсний дараа
 2. Төрөхөөс өмнө
 3. Хөхний сүүгээр

4. Төрөх үед
 5. Жирэмслэхээс өмнө
- /351./ Нярай хүүхэд амьдралын эхний хоногуудад шээс нь ховорддог шалтгаан
1. Шингэн уулгаагүйгээс
 2. Дулаан өлгийдөж, халууцуулснаас
 3. Бөөрний дутагдлаас
 4. Бие махбод шингэнээ хадгалах үүднээс авч буй физиологийн үзэгдэл
 5. Ангир уураг хэт багаас
- /352./ Амьсгалын дистресс хамшинжийн үед авах арга хэмжээний зарчмыг заана уу.
1. Хүүхдийг тайван байлгах
 2. Нярайг дулаан байлгах
 3. Салиаг сайтар соруулж, хахахаас сэргийлэх
 4. Хүчилтөрөгч өгөх
 5. Амьсгал зүрх судасны үйл ажиллагааг тогтмол хянах
- /353./ Даарсан хүүхдийг хэрхэн дулаацуулах вэ?
1. Нярайг нүцгэлж, эхийн нүцгэн цээжинд наана
 2. Толгойд малгай өмсгөнө
 3. Хөхүүлнэ
 4. Халуун усанд оруулна
 5. Эмнэлэгт яаралтай илгээнэ
- /354./ Бүтэлтийн зөв тодорхойлолтыг тэмдэглэнэ үү
1. Амьсгалахгүй, зүрх цохилохгүй, амьдын шинжгүй төрөх
 2. Ураг орчмын шингэн булингартай байх
 3. Хүүхэд төрмөгц уйлахгүй байх
 4. Амьд төрөлтийн бусад шинж илэрч байвч хүүхэд амьсгалахгүй буюу амьсгалын хэм алдагдах
 5. Нярай хэвийн амьсгалж байснаа хэсэг хугацааны дараа амьсгалахгүй болж, царай хөхрөх
- /355./ Сурфактант ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
1. Уушгины дотор хананы гадаргууны таталцлыг ихэсгэнэ
 2. Цулцангийн дотор хананы гадаргууны таталцлыг багасгана
 3. Авчилз үүсгэнэ
 4. Цулцангууд хоорондоо наалдахаас сэргийлнэ
 5. Уушгины агааржилтыг бууруулна
- /356./ Нярайн хүй өтгөнөөр бохирдсон, идээлж, улайгаагүй байвал яаж цэвэрлэх вэ?
1. Антибиотиктой цацлага хийнэ
 2. Цэвэр зүйлээр дарж бооно
 3. Спиртээр цэвэрлэнэ
 4. Савантай буцалсан бүлээн усаар угааж, хуурайшуулна
 5. Эмнэлэгт хэвтүүлнэ
- /357./ Хламидын шалтгаант нүдний үрэвслийг хэрхэн эмчлэхийг заана уу.
1. Тетрациклины тосон түрхлэг хэрэглэнэ
 2. Эритромицины тосон түрхлэг хэрэглэнэ
 3. Пенициллин тарина
 4. Эритромицины сироп уухаар хэрэглэнэ
 5. Ампициллин тарина
- /358./ Дараах шинжүүдийн аль нь халдварын үед аюултай шинжид орох вэ?
1. Амьсгалын тоо олширох
 2. Ихээр бөөлжих ба суулгах
 3. Чээж хүчтэй хонхолзох
 4. Биеийн халуун хэт буурах
 5. Татах
- /359./ Нярайн халдварын эмчилгээний зарчимд орохгүй зүйлийг нэрлэ
1. Антибиотик эмчилгээ
 2. Дэмжих эмчилгээ
 3. Шинж тэмдгийн эмчилгээ

4. Эхийн сүүгээр хооллохгүй, тусгаарлах
 5. Вирүсийн эсрэг эмчилгээ
- /360./ Гэдэсний үхжилт үрэвслийн үед авах арга хэмжээг заана уу.
1. Амаар хооллолтыг зогсоох
 2. Ходоодонд байнгын гуурс тавьж тагийг онгорхой орхих
 3. Ходоодны агууламж, баасанд цус буйг тодорхойлох
 4. Антибиотик эмчилгээ хийх
 5. Судсаар хооллох
- /361./ Тээлтийн 32 долоо хоногтой, 1600 г жинтэй, 5 хоногтой дутуу нярайг хооллох аргыг заана уу.
1. Судсаар
 2. Ходоодны гуурсаар
 3. Угжаар
 4. Жижиг аяга буюу хундагаар
 5. Хөхөөр
- /362./ Амьсгалын дистресс хамшинжийн хүндрэлд аль нь хамаарах вэ?
1. Артерийн цорго битүүрээгүй
 2. Тархины ховдлын эргэн тойронд цус харвах
 3. Үрэвсэлт өөрчлөлт илрэх
 4. Хүчилтөрөгч эмчилгээний хүндрэл үүсэх
 5. Уушгинд цус харвах
- /363./ Бүтэлтийн хожуу үед дараах хүндрэлээс аль нь тохиолдож болох вэ?
1. Халдвар (уушгины хатгалгаа, мэнэн)
 2. Мэдрэлийн эмгэгүүд
 3. Хүчилтөрөгч эмчилгээний хүндрэл
 4. Ургийн цусны эргэлт эргэж сэргэх
 5. Бөөрний цочмог дутагдал
- /364./ Нярайн шарлалтын шалтгааныг заана уу.
1. Цөсний сувгийн төрөлхийн битүүрэл
 2. Төрөлхийн цитомегаловирүсийн халдвар
 3. Элэгний үрэвсэл
 4. Төрөлхийн тэмбүү
 5. Галактоземи
- /365./ Төрөх өрөөнд сахих нярайн дулаан хэлхээг заана уу.
1. Төрөх өрөө нэвт салхигүй байх
 2. Нярайг төрмөгц хуурайшуулах
 3. Төрөх өрөөний дулаан 25 хэмээс доошгүй байх
 4. Малгай өмсгөх
 5. Нярайг чанга өлгийдөж, халаалттай ширээн дээр тавих
- /366./ Нярайн үжлийн шүүлтүүрт аль нь орох вэ?
1. Цусны лейкоцит >5000
 2. Улаан эсийн тунах хурд >15 мм/цаг
 3. Залуу эс, нийт нейтрофилийн харьцаа < 0
 4. С-урвалж уураг эерэг байх
 5. Цусны цагаан эс <20000
- /367./ Нярай хүүхэд дулаан алдахаас сэргийлэхэд аль нь буруу вэ?
1. Эхийн нүцгэн биед нааж, дулаан хучих
 2. Төрмөгц нь хуурайшуулах
 3. Өрөө тасалгаа дулаан байх
 4. Чанга өлгийдөх
 5. Малгай өмсгөнө
- /368./ Цус задрах өвчний үед цус орлуулан сэлбэх эмчилгээний заалтыг нэрлэнэ үү.
1. Цусны билирубин >342 мкмол/л
 2. Билирубины цагийн өсөлт >6 мкмол/л
 3. Хүйн цусанд билирубиний хэмжээ >60 мкмол/л
 4. Цусны билирубин >205 мкмол/л

5. Хүйн цусанд билирубины хэмжээ >45 мкмол/л
- /369./ Шилжилтийн үеийн амьсгаадалт ямар хүүхдэд элбэг тохиолдох вэ?
1. Кесар хагалгаагаар төрсөн нярай
 2. Өгзөг төрүүлэлтээр төрсөн хүүхэд
 3. Эхэд өвчин намдаах эм хэрэглэсэн
 4. Бүтэлттэй төрсөн нярай
 5. Уургийн дутагдалтай нярай
- /370./ Түгээмэл тохиолдох амьсгалын дистресс хамшинжид дараахын аль нь орох вэ?
1. Уушгины үрэвсэл
 2. Зунгагт хахах
 3. Пневмоторакс
 4. Уушгинд цус харвах
 5. Цусны чихэр багадалт
- /371./ Хүйг хэдийд таслан, хавчвал зохистой вэ?
1. Нярайг төрөнгүүт
 2. Төрсний дараа 5-10 минутын дараа
 3. Ихэс салсны дараа
 4. Ойролцоогоор 1 минутын дараа хүйн лугшилт зогссоны дараа
 5. 30 секундын дараа
- /372./ Нярай хүүхдэд антибиотикийг хэрхэн сонгох вэ?
1. Нярайд өвчин үүсгэгчийн эсрэг хамгийн сайн үйлчлэх антибиотикийг сонгоно.
 2. Антибиотик мэдрэгийг тодорхойлох боломжгүй, эхэлж хийсэн антибиотикт сайжрал өгөхгүй бол хоёр дахь сонголтын антибиотикийг хэрэглэх буюу антибиотикийг хавсарч хэрэглэнэ
 3. Хоёрдугаар сонголтын антибиотикийг 3 дахь өдрөөс хийж эхэлнэ.
 4. Үүсгэгчийг тодорхойлсны дараа антибиотикийг өөрчилнэ
 5. Заавал 3 антибиотик хавсарч хэрэглэнэ
- /373./ Төрөх өрөөнд ургийн ус эрт гарсан, илүү тээлттэй эх төрөх гэж байна. Нярайд шаардлагатай хэрэгслийг бэлдэнэ үү.
1. Дулаан цацруулагчтай ширээ
 2. Нярайг хуурайшуулах даавуу, дулаан өлгий
 3. Салиа соруулах төхөөрөмж
 4. Хүүдий, маск
 5. Шаардлагатай эм
- /374./ Эх нярай 2 төрөхөөс гарч байна. Таны өгсөн зөвлөгөөнд байж боломгүй нь:
1. Хөхөөрөө хоолло, хүссэн үед нь хөхүүл
 2. Хүй бохирдвол савантай бүлээн усаар угааж хатаа
 3. Өрхийн эмч сувилагчаас зөвлөгөө авч байх
 4. Хүйтний улирал тул гадаа гаргаж болохгүй ба сард 1 удаа усанд оруул
 5. Аюултай шинжийг ажиглах
- /375./ Гэдэсний үхжилт үрэвслийн үед гэдэс-ходоодны талаас гарах өөрчлөлтүүдийг заана уу.
1. Гэдэс дүүрэх
 2. Ходоодны үлдэгдэл агууламж ихсэх буюу хоол шингэхгүй байх
 3. Бөөлжих
 4. Цустай баах
 5. Хэвлийн хана улайх
- /376./ Таргалалтыг Иценко-Кушингийн хамшинжээс ялган оношилохдоо дараах шинжилгээг хийнэ
1. Шээсний 17-ОКС
 2. АКТГ ба кортизол
 3. Гонадотропин
 4. Тестостерон
 5. Цусны электролитүүд
- /377./ Уушгины бус гаралтай амьсгалын дистресс хамшинжийн шалтгааныг заа
1. Ургийн цусны эргэлт давтагдах

2. Тархины хаван
3. Зүрхний төрөлхийн гажиг
4. Бодисын солилцооны хямрал
5. Тархи-нугасны гэмтэл

/378./ Нярайн гемостазын онцлог юу вэ?

1. Улаан эс 1 мм³-т 6.09 сая
2. Хоёр төрлийн гемоглобин агуулдаг
3. Цусан дахь фибриногений хэмжээ бага
4. Цус бүлэгнэлтийн II, VII, IX, X хүчин зүйлс бага
5. Эргэлдэх цусны хэмжээ биеийн цулын 11%-тай тэнцүү

/379./ Нярайн үжил ба мэнэнгийн үед 1-р сонголтын антибиотик аль нь вэ?

1. Прокайн пенициллин
2. Гентамицин
3. Эритромицин
4. Ампициллин
5. Клоксациллин

/380./ Хөх чинэсэн үед хүүхдээ хөхүүлэхийн өмнө окситоцины ялгаралтыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?

1. Бүлээн шүршүүрт орох
2. Хөхөндөө иллэг хийх
3. Хөхний толгойг имрэх
4. Хөхөндөө бүлээн жин тавих
5. Хүзүү нуруунд иллэг хийх

/381./ Үжлийн үед эрт илрэх шинж тэмдгийг дурьдана уу.

1. Биеийн халуун хэлбэлзэх
2. Амьсгалын тоо олшрох
3. "Цагаан толбо"-ны шинж 3 секундээс удаан хадгалагдах
4. Арьс эрээнтэх
5. Гэдэс дүүрэх

/382./ Нярай хүүхэд дулаанаа алдах замуудыг нэрлэнэ үү.

1. Зулайгаар дулаанаа цацруулах
2. Орчиндоо шилжүүлж алдах
3. Хавьтлын замаар
4. Ууршлын замаар
5. Агаар дуслын замаар

/383./ Эрт илрэлтэй үжлийн үед ихэвчлэн тохиолдох үүсгэгчийг заана уу.

1. Псевдомонас
2. В-бүлгийн стрептококк
3. Стафилококк
4. Гэдэсний савханцар
5. Клебсиел

/384./ Амьсгалын дистресс хамшинжийн эмнэлзүйн шинж тэмдгийг заана уу.

1. Амьсгалын тоо олширох
2. Яраглах
3. Чээж хонхолзох
4. Хөхрөх
5. Хамрын угалз сарталзах

/385./ Диабетийн эмнэлзүйн шинжүүд илрэхээс өмнө дараах шинжилгээнээс алийг нь хийх нь хамгийн зөв бэ?

- A. Глюкоз тэсвэрлэх чадвар тодорхойлох сорил
- B. Глюкозжсон гемоглобин
- C. Өлөн үед сахарыг тодорхойлох
- D. Шээсээр ялгарах сахарыг хэмжих
- E. Генетикийн шинжилгээ хийх

/386./ 1-р хэлбэрийн диабеттэй өвчтөнд хоногт хэрэглэх инсулины дээд тун хэд байж болох вэ?

- A. 0.1 ед/кг
- B. 0.5 ед/кг
- C. 0.75 ед/кг
- D. 1.0 ед/кг
- E. 1.2 ед/кг

/387./ Охидын эсрэг хүйс дагасан (гетеросексуаль) хуурамч ББЭЭ, хөвгүүдийн хүйсээ дагасан (изосексуаль) ББЭЭ нь ихэнхдээ дараах шалтгаантай

- A. Аденогениталь хамшинж
- B. Бөөрний дээд булчирхайн эстроген илүүтэй ялгаруулагч хавдар
- C. Эктопик Кушингийн хамшинж
- D. Өнчин тархины хавдар
- E. Төмсөгний хавдар

/388./ Бөөрний дээд булчирхайн цочмог дутагдалтай аденогениталь хамшинжтэй өвчтөнд дараахаас бусад шингэнийг сэлбэнэ.

- A. 0.9% физиологийн уусмал
- B. 5%-ийн глюкозын уусмал
- C. 10%-ийн декстрозын уусмал
- D. 7.5% кали хлорын уусмал
- E. 5% декстрозын уусмал

/389./ Жинхэнэ ББЭЭ-ийн эмчилгээнд хамгийн үр дүнтэй эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү

- A. Гонадотропин-рилизинг дааврын суперантогонист
- B. Decareptyl-Depot
- C. Бусерелин (Suprefact)
- D. Андрокур
- E. Depot Provera